

## **ТӨВ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2020 ОНЫ 07 ДУГААР САРД ХИЙСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ**

2020 оны 07 дугаар сарын 31

Зуунмод

Төв аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хэмжээнд 2020 оны 07 дугаар сард хийсэн ажлын мэдээллийг танилцуулж байна.

### **Нэг. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба:**

Аймгийн ИТХ, Тэргүүлэгчид, Ажлын албанаас 7 дугаар сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Аймгийн ИТХ-ын 17 дугаар хуралдаан 2020 оны 07-р сарын 02-ны өдөр, Тэргүүлэгчдийн Х хуралдаан 7-р сарын 22, Тэргүүлэгчдийн ээлжит бус-2 дугаар хуралдаан 07-р сарын 01-ний өдөр тус тус хуралдлаа.

### **Аймгийн ИТХ-ын XVII хуралдаанаар:**

1. Аймгийн 2019 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тухай өргөн мэдүүлсэн тайлан, төсөл, тэдгээрт Хурлын Эдийн засаг, төсөв санхүү, өмчийн бодлогын хороо, Төв аймаг дахь Төрийн Аудитын газраас хийсэн дүгнэлтүүдийг хэлэлцээд аймгийн 2019 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэлээр төсвийн нийт орлогыг 23862.0 сая төгрөг, аймгийн төрийн сан дахь жилийн эцсийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 12356.5 сая төгрөг, төсвийн зарлагын гүйцэтгэлийг 81195.0 сая төгрөгөөр батламжлав .

2. Аймгийн 2020 оны төсөвт тусгагдсан хөрөнгө оруулалтын ажил, худалдан авах ажиллагааны эхний 5 сарын гүйцэтгэл, тендерийн хэмнэлтийн талаар аймгийн Засаг даргын мэдээлэл, өргөн мэдүүлсэн төсөл, түүнд Хурлын Эдийн засаг, төсөв, санхүү, өмчийн бодлогын хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны арван тавдугаар хуралдааны “Аймгийн 2020 оны төсөв батлах тухай” 02 дугаар тогтоолын 10 дугаар заалтаар батлагдсан “Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт” гэсэн нэгдүгээр хавсралтад өөрчлөлт оруулж “Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай ” тогтоолыг батлав .

3. Сумын хамгаалалтад байх Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт баталж, орчны газрыг нь орон нутгийн хамгаалалтад авах тухай аймгийн Засаг даргын мэдээлэл, өргөн мэдүүлсэн төсөл, тэдгээрт Хурлын Нийгмийн бодлогын Хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд сумын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг нэгдүгээр, тэдгээрийн орон нутгийн хамгаалалтад авах орчны газрын солбицлын цэг, хэмжээг хоёрдугаар, улс, орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газарт байгаа дурсгалуудын хамгаалалтын бүсийн солбицлын цэгийг гуравдугаар хавсралт ёсоор тус тус батлав.

Аймгийн нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хамгаалалтыг сайжруулах талаар батлагдсан тус тогтоолын 1 дүгээр заалтын жагсаалтад дурдсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудын бүрэн бүтэн байдлыг хамгаалж, хяналт тавьж ажиллах, тэдгээрийг сэргээн засварлахад шаардагдах хөрөнгийг аймгийн жил жилийн төсөвт тусган батлуулж, хэрэгжилтийг хангах, “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.5 дахь заалтын дагуу аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг холбогдох байгууллагаар батлуулж, тэдгээрийн орчны газрыг аймгийн тусгай хамгаалалтад авахуулах ажлыг зохион байгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг даргын орлогчид даалган “Сумын хамгаалалтад байх Түүх , соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт баталж, орчны газрыг нь орон нутгийн хамгаалалтад авах тухай” тогтоолыг батлав.

4. Зарим газар нутгийг аймгийн тусгай хэрэгцээ, хамгаалалтаас чөлөөлж, бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авах тухай аймгийн Засаг даргын мэдээлэл, түүнд Хурлын Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд Заамар сумын 3-р багийн нутаг “Тосон” гийн 0.6 га, “Галтын амны хойд ар” -ын 5 га, “Салтгарын урд энгэр” -ийн 1.5 га, “Урд баясгалант” -ын зүүн талын 0.91 га, нийт 4 байршлын 8.01 га газруудыг аймгийн Тусгай хэрэгцээнээс тус тус хэсэгчлэн чөлөөлсүгэй.

Энэ тогтоолын 1дүгээр заалтаар аймгийн тусгай хэрэгцээнээс чөлөөлөгдсөн нийт 4 байршлын 8.01 га талбайг бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авч, талбайн булангийн цэгүүдийн солбицол, хэмжээ, тусгай хэрэгцээнд байлгах хугацаа, байршлын нэрийг батлан бичил уурхайн талаар “Газрын тухай”, “Ашигт малтмалын тухай”, “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулиуд, Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”, 2019 оны “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 355, 2020 оны “Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, түүнд тавих хяналтыг сайжруулах, хууль бус үйлдлийг таслан зогсоох талаар авах зарим арга хэмжээний тухай” 17

дугаар тогтоолуудын бичил уурхайн үйл ажиллагааг зохицуулсан заалтуудын хэрэгжилтийг хангах , аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны есдүгээр хуралдааны 06 дугаар тогтоолоор бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан Заамар сумын 6, Баян сумын 2, Баянжаргалан сумын 1 нийт 9 байршил газар, энэхүү тогтоолоор аймгийн тусгай хэрэгцээнд авсан 4 байршил нийт 13 байршил газарт холбогдох сумдын Засаг дарга нар бичил уурхай ажиллуулж гэрээ байгуулан, хяналт тавьж ажиллаж байгаад тодорхой хуваарийн дагуу хяналт шалгалт хийж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллах, холбогдох хууль, тогтоомжид заасан бичил уурхай эрхлэгчдэд тавигдах шаардлагыг хангаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нөхөрлөлийн үйл ажиллагааг зогсоож, гэрээг цуцлах арга хэмжээ авах, Бичил уурхайгаар ашигт малтмал олборлосон газрын нөхөн сэргээлтийн ажилд онцгойлон анхаарч, хяналт шалгалтын дүнг үндэслэн нөхөн сэргээлтийг сандартын дагуу хийлгэж хүлээн авах ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг даргад даалгав. Заамар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 04 дүгээр тогтоолоор орон нутгийн тусгай хэрэгцээнээс чөлөөлсөн 66 байршил газраас 4 байршил газрыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авсантай холбогдуулан үлдсэн 62 байршил газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд эргүүлэн авах, сумын хэмжээнд бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газрууд, тэдгээрт ажиллаж буй нөхөрлөлүүдийн үйл ажиллагаанд хууль, тогтоомжийн дагуу хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Заамар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөв .

5. Аймгийн ИТХ-ын төлөөлөгчөөс чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцээд Аймгийн ИТХ - ын Төлөөлөгч, Засаг дарга Ж.Батжаргал нь Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн 14 дүгээр тойрогт МАН - аас нэр дэвшин өрсөлдөж, УИХ - ын гишүүнээр сонгогдсон тул аймгийн ИТХ - ын Төлөөлөгчөөс чөлөөлөгдөх тухай өргөдөл, Төлөөлөгч Н.Энхбаатар нь 2019 оны 07 дугаар сарын 30-ны өдөр Нийслэлийн Замын хөдөлгөөн тээвэр зохицуулалтын газрын Захиргааны хэлтсийн даргаар томилогдож, аймгийн ИТХ - ын Төлөөлөгчөөс чөлөөлөгдөх өргөдлөө тус тус ирүүлсэн бөгөөд аймгийн ИТХ - ын Төлөөлөгч Ж.Батжаргал, Н.Энхбаатар нарыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчөөс 2020 оны 07 дугаар сарын 02-ны өдрийг дуусгавар болгон чөлөөлөв. Аймгийн ИТХ - ын ээлжит 17 дугаар хуралдаанаар 5 асуудал хэлэлцэж 5 тогтоол батлав.

#### **Аймгийн ИТХ - ын Тэргүүлэгчдийн ээлжит бус-II хуралдаанаар:**

1. Аймгийн ИТХ-ын 2019 оны 15 дугаар хуралдааны “ Аймгийн 2020 оны төсөв батлах тухай ” 02 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцээд “ Хуралдаанаар хэлэлцэх асуудалд нэмэлт оруулах тухай ” тогтоолыг батлав .

2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 17 дугаар хуралдаанаар хэлэлцэх 5 асуудалд Хурлын Эдийн засаг , төсөв санхүү өмчийн бодлогын хороо , Нигимийн бодлого , Байгаль орчин хөдөөгийн хөгжлийн хороо , Нутгийн удирдлага хууль хяналт гадаад харилцааны хороодоос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд Хурлын хуралдаанд шилжүүлэв .

#### **Аймгийн ИТХ - ын Тэргүүлэгчдийн X хуралдаанаар:**

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн ажлыг зохион байгуулах Сонгуулийн хороог 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж “ Аймгийн Сонгуулийн хороо байгуулах тухай ” тогтоолыг батлав.

2. Аймгийн эдийн засаг Нигмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцыг хэлэлцээд хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгөв.

3. “Хүртээмжтэй , чанартай төрийн үйлчилгээ ” 2020 оны урианы жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг хэлэлцээд хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгөв.

4. Нутгийн удирдлагын шийдвэрийн /ИТХ , ИТХТ - ийн тогтоол, тэмдэглэл/ хэрэгжилтэд хийсэн Хяналт шинжилгээ, үнэлгээний тухай асуудлыг хэлэлцээд хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгөв .

5. “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн үйлдвэржүүлэх “ЖДҮ:27” төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгөв.

6. Аймгийн “Авто зам, Авто тээврийн салбарыг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө” -ний /2017-2024/ хэрэгжилтийн явцыг хэлэлцээд хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгөв.

7. Хөрөнгө шийдвэрлэх тухай

8. “Төрөөс ойн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө ”-ний биелэлтийг дүгнэх тухай

9. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг дүгнэх тухай

10. Төрийн одон медальд уламжлах тухай

11. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийг чөлөөлөх тухай зэрэг нийт 11 асуудал хэлэлцэж 6 тогтоол батлан хуралдааны тэмдэглэлээр 5 үүрэг өгөв.

Аймгийн ИТХ-ын 17 дугаар хуралдаан, Тэргүүлэгчдийн Хуралдаанаас батлагдан гарсан тогтоолуудыг аймгийн ИТХ-ын Khural.mn сайт, аймгийн ЗДТ -ын мэдээллийн самбар, Нэгдсэн үйлчилгээний төвийн мэдээллийн самбарт байршуулан нийтэд мэдээлж ажилласан.

Их Монгол улс байгуулагдсаны 811, Ардын хувьсгалын 98, Аймаг байгуулагдсаны 96 жилийн ойг хамтатган тэмдэглэх чиглэл өгсний дагуу 2020 оны 7-р сарын 8-10 -ны өдрүүдэд тэмдэглэж өнгөрүүлсэн.

Энэ үеэр аймаг орон нутгийнхаа хөгжлийн тэргүүлэх чиглэл болсон Хөдөө аж ахуй, Эдийн засаг, нийгэм, Дэд бүтэц, Төр, захиргааны олон жил үр бүтээлтэй ажилласан хүмүүсийг Монгол улсын Төрийн дээд одон медаль болон салбарын тэргүүн, аймгийн ИТХ, Засаг даргын шагналаар шагнаж урамшууллаа.

Энэ сард аймгийн ИТХ-ын дарга , Ажлын албанд хандсан 22 албан бичиг ирснийг бүртгэн аймгийн ИТХ-ын дарга болон нарийн бичгийн даргад танилцуулан хариу өгөх шаардлагатай 4 бичигийн хариуг өгч ажиллалаа.

Аймгийн ИТХ - ын дарга, Хурлын Ажлын албанаас Ерөнхийлөгчийн Тамгын газар, салбарын яамдуудад болон холбогдох албан байгууллагад 14 бичгийг гарган хүргүүлж ажилласан байна.

Аймгийн ИТХ - ын даргад хандан иргэдээс 4 өргөдөл ирүүлснээс Алтанбулаг сумын иргэн Г.Наранхүү, Зуунмод сумын иргэн С.Алтанбаяр, Заамар сумын Хайлааст багийн иргэн Ц.Өлзийсайхан нарын өргөдлийн хариуг хугацаанд нь албан бичгээр хариу өгч шийдвэрлэсэн.

Аймгийн ИТХ - ын төлөөлөгч Г.Мөнхбадрал, Ж.Баттөгс нараас ирүүлсэн өргөдлийн хариуг аймгийн ИТХ - ын Тэргүүлэгчдийн Хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлэсэн байна .

2020 оны 7-р сарын 17-22 ны өдрүүдэд зохион байгуулагдсан Төвийн бүсийн аймгуудын ИТХ-ын Ажлын албаны ажилчдын туршлага солилцох уулзалт зөвлөгөөнд аймгийн ИТХ-ын Ажлын албаны ажилчид оролцов .

Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлөөс Төв аймагт ажиллаж Үндэсний аюулгүйн байдлын талаар баримтлах бодлогын баримт бичиг боловсруулах талаар арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

#### **Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах ажлын хүрээнд:**

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах аймгийн салбар комиссоос нэхэмжлэл гаргагч Х.Цолмон, Ч.Сэрчмаа, С.Цэндсүх нарын Төв аймгийн сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхээс гарсан шийдвэрийг тухай бүр бүртгэж цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисст хүргүүлж ажиллалаа.

#### **Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:**

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аймгийн салбар зөвлөлийн эхний хагас жилийн ажлын тайлан мэдээг гаргаж Монгол улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд хүргүүлж ажилласан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аймгийн салбар зөвлөлийн 2020 оны 1 дүгээр тогтоолоор томилогдсон ажлын хэсэг Баянчандмань, Борнуур, Жаргалант Батсүмбэр, Сүмбэр сумдын нутаг дэвсгэрт “Устгал” нэгдсэн арга хэмжээг 6 сарын 29-өөс 7-р сарын 17-ны өдрүүдэд зохион байгуулж, холбогдох зардлыг гэм хэргээс урьдчилан сэргийлэх зохицуулах зөвлөлөөс шийдвэрлэж 2712.0 мянга төгрөгийн дэмжлэг үзүүлж ажилласан байна.

#### **Хоёр. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүрээнд:**

##### **Нутгийн удирдлага, хамтын ажиллагааны хүрээнд**

“Хүртээмжтэй, чанартай төрийн үйлчилгээ” 2020 оны урианы жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилт 2 дугаар улирлын байдлаар 68.33%-тай гарсан бөгөөд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Хуралдаанаар хэлэлцүүлж тус хуралдаанаар тэмдэглэлээр үүрэг өгсөн болно.

Аймгийн Засаг даргын орлогчийн баталсан удирдамжийн дагуу 2020 оны 07 дугаар 30-31-ны өдрүүдэд Баян-Өнжүүл, Бүрэн, Баяндэлгэр, Мөнгөнморьт, Баянхангай, Угтаалцайдам сумдад батлагдсан үзүүлэлтийн хүрээнд 3 ажлын хэсэг үйл ажиллагааны явц, үр дүнгийн талаар шалган туслах ажлыг зохион байгуулж ажиллав.

Засгийн газрын 1111 төсвөөс 07 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар өссөн дүнгээр 25 өргөдөл гомдол хуваарилагдан ирсний 18 нь шийдвэрлэгдэн 7 шийдвэрлэх шатандаа байна. Аймгийн Засаг даргын 2017 оны “аймгийн төрийн байгууллага, албан тушаалтан иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-д туссаны дагуу сар бүрийн эхэнд зохион байгуулагддаг “Иргэдтэй уулзах цаг”-ийг 07 дугаар сарын 01-ний өдөр Зуунмод сумын 6 багт зохион байгуулж иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэсэн байна. Шийдвэрлэлтийн хувийг хүснэгтээр харуулбал:

| Сар | Иргэдийн тоо | Гаргасан санал, үзэгдэл | Шийдвэрлэлт            |                               |                  | Шийдвэрлэлтийн хувь |
|-----|--------------|-------------------------|------------------------|-------------------------------|------------------|---------------------|
|     |              |                         | Шийдвэрлэж хариу өгсөн | Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн | Хугацаа болоогүй |                     |
| 7   | 69           | 84                      | 66                     |                               | 18               | 78.57               |

Аймгийн ИТХ-ын ажлын алба, ЗДТГ, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд, сумдаас 2020 оны эхний хагас жилийн байдлаар иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг хүлээн авч нэгтгэн ЗГХЭГ-т хүргэлээ. Шийдвэрлэлтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

2020 оны эхний хагас жилд иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээлэл

| №           | Нэр                     | Нийт | Шийдвэрлэлт            |                               |                               |                  | Шийдвэрлэлтийн хувь |
|-------------|-------------------------|------|------------------------|-------------------------------|-------------------------------|------------------|---------------------|
|             |                         |      | Шийдвэрлэж хариу өгсөн | Бусад байгууллагад шилжүүлсэн | Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн | Хугацаа болоогүй |                     |
| 1           | Аймгийн ИТХ             | 7    | 6                      |                               |                               | 1                | 85,71               |
| 2           | Аймгийн ЗДТГ            | 159  | 105                    | 30                            |                               | 2                | 84,91               |
| 3           | Сумд                    | 5521 | 5130                   | 47                            | 12                            | 285              | 94,79               |
| 4           | Харьяа агентлаг, хэлтэс | 1175 | 1102                   | 7                             |                               | 66               | 94,38               |
| Нэгдсэн дүн |                         | 6815 | 6343                   | 84                            | 12                            | 376              | 94,48               |

Аймгийн удирдлагуудын нэгдсэн шуурхайг 07 дугаар сарын 06, 27-ны өдрүүдэд 2 удаа зохион байгуулж нийт 33 үүрэг даалгавар өгөгдсөн байна. 07 дугаар сарын 06-ны өдрийн нэгдсэн шуурхайн хэрэгжилт 80.0%-тай, 07 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн шуурхайн хэрэгжилт тооцох хугацаа болоогүй байна.

Аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн хуралдааныг 07 дугаар 06, 21-ны өдрүүдэд 2 удаа зохион байгуулж ажилласан байна. 07 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаар 12, 21-ний өдрийн хуралдаанаар 6 нийт 18 асуудал хэлэлцэж холбогдох шийдвэрийг гаргаж ажилласан байна.

#### **Гадаад харилцаа:**

БНСУ-ын Кёнги аймгийн Пёнктаек хотын захиргааны дэмжлэгээр хийгдэх аймгийн Нийтийн номын сангийн их засварын ажлын 30 хувийн гүйцэтгэлийн тайлан, зураг төсвийн санхүүжилттэй холбоотой шаардагдах материалыг орчуулан хүргүүлэв.

БНХАУ-ын Энхтайван хөгжлийн сангийн санхүүжилтээр хийгдэх Төв аймгийн Зсурсуулийн үдийн хоолны өрөөг засварлах төслийн санхүүжилт хүссэн албан бичгийг хүргүүлж, урьдчилгаа 70 хувь болох 98000 ам.долларыг Сангийн ямаар дамжуулан хүлээн авав.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн 14-р тойргоос Төв аймгийн Засаг дарга Жигжидийн Батжаргал Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдож, Засаг даргын орлогч Д. Мөнхбаатар 2020 оны 07 сарын 02-ны өдрөөс Засаг даргыг шинээр томилох хүртэл хугацаанд бүрэн эрхийг хэрэгжүүлэн ажиллах болсон тухай албан бичгийг харилцаат мужуудад хүргүүлэв.

Төв аймагт тохиолдсон үер усны гамшигт үзэгдлийн сэргээн босголтод харилцаат мужуудаас чин сэтгэлийн дэм үзүүлж, Япон улсын Тоттори мужаас 500,000 иен, Изүмисано хотоос 500,000 иен, Изүмисано хотын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 200,000 иен, Хотын захиргааны албан хаагчдаас 50,000 иен, нийт 1,250,000 иений мөнгөн хандив цуглуулан ирүүлснийг Монгол улсын Гадаад харилцааны яамны Ази номхон далайн орнуудын газраас Э. Сарантогос 2020.07.28-ны өдөр албан ёсоор хүлээн авсан.

#### **Төрийн үйлчилгээний нэгдсэн төв:**

2020 оны 7 дугаар сард Төрийн болон бизнесийн дэмжих үйлчилгээний нийт 23 байгууллага 300-аад төрлийн үйлчилгээг 5300 иргэнд, өдөрт дунджаар 250-300 иргэнд хүргэж байна. Аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй ажил үйлчилгээ, арга хэмжээний мэдээллийг “Өлзий”, TBS, Төв, Live TV, Сүлд телевизүүд, аймгийн албан ёсны веб сайт, пейж хуудас, мэдээллийн болон урсдаг самбар зэрэг эх сурвалжаар иргэд, олон нийтэд түгээж байгаа бөгөөд 7 дугаар сард аймгийн веб сайтад 25, “Төв аймгийн Хэвлэл мэдээллийн алба” пэйж хуудсанд 49 мэдээ мэдээлэл тус тус нийтлэгдлээ. Харин 7 хоног бүрийн Лхагва гаригт цацагддаг “Төв аймгийн цаг” нэвтрүүлгийн 5-н дугаарт 22 бүрэн хэмжээний нэвтрүүлэг бэлтгэн өгч, олон нийтэд хүргэсэн. Мөн бусад 7 төрлийн

телевизүүдийн мэдээний цагаар 20 мэдээ мэдээлэл гарсан нь давтагдсан тоогоор 270 удаа цацагдсан байна.

Төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой санал, гомдлыг хүлээн авдаг 7027-1111 нээлттэй утсанд 9 гомдол ирснийг холбогдох хэлтэс, агентлагуудад уламжлан шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллаж байна.

#### **Мэргэжлийн хяналтын газрын үйлчилгээ:**

#### **Төлөвлөгөөт хяналт шалгалт:**

#### **Эмчилгээний чанарын хяналтын чиглэлээр:**

Мэргэжлийн хяналтын газрын 2020 оны 19/108 тоот удирдамжийн дагуу Заамар сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг 3.32.1 кодтой Сум тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний чанар, аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудсаар төлөвлөгөөт шалгалт хийхэд хууль сахин мөрдөлт 44.8 хувь, эрсдэл үүсэх магадлал 45.9 хувьтай буюу дунд эрсдэлтэй үнэлэгдсэн. Улсын байцаагчийн хамтарсан албан шаардлагад 10 заалт оруулсан. Мэргэжлийн хяналтын газрын 2020 оны 19/08 тоот удирдамжийн хүрээнд Заамар, Угтаал, Цээл, Баянцогт, Аргалант сумын эрүүл мэндийн төвд төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Урьдчилан сэргийлэх шалгалтын явцад Угтаал, Цээл сумын эрүүл мэндийн төвд АНЭ-ийн эх барих эмэгтэйчүүдийн их эмч Л.Цэрэндолгор эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлгүйгээр оношилгоо, эмчилгээ үйлчилгээ үзүүлж байсныг илрүүлж Эмчлэх, сувилах, эх барих сэргээн засах үйл ажиллагааг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн зөрчлийг таслан зогсоож Зөрчлийн тухай хуулийн 6.7-ийн 1 дэх заалтаар арга хэмжээ тооцсон.

#### **Боловсролын чиглэлээр:**

2020 оны Элсэлтийн ерөнхий шалгалтын зохион байгуулалтад 07 сарын 02-05-ны өдрүүдэд урьдчилан сэргийлэх хяналт тавьж боловсрол, эрүүл ахуйн чиглэлийн 4 байцаагч ажиллалаа. Элсэлтийн ерөнхий шалгалтыг зохион байгуулах үед коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх түр журам, МХЕГ-ын улсын ахлах байцаагчийн зөвлөмж, 2020 оны элсэлтийн ерөнхий шалгалтын журмын хэрэгжилт, 10 төрлийн хичээлийн шалгалтуудын материалын битүүмжлэл, шалгалтын сэдвийн хамгаалалт, нууцлалыг хангасан байдал, элсэлтийн ерөнхий шалгалтын явцад урьдчилан сэргийлэх хяналт хийв.

Нийт 10 төрлийн хичээлээр 797 шалгуулагч шалгалт өгөхөөр бүртгүүлснээс давхардсан тоогоор 2422 шалгуулагч орж 90.0%-ийн ирцтэй шалгалт өгчээ. Шалгалтын байрны үйл ажиллагааг хэвийн зохион байгуулах зорилгоор Хүмүүн цогцолбор сургуулийн багш ажилтан бусад шаардлагагүй хүмүүсийг оруулахгүй байх, шалгуулагч болон эцэг эхийг бөөгнөрөл үүсгэхгүй байхад анхаарч ЦГ, ОБГ, МХГ-ынхан хамтарч ажиллав.

Элсэлтийн ерөнхий шалгалтыг шударга, нээлттэй, ил тод зохион байгуулах зорилгоор аймгийн Засаг даргын захирамжаар 5,4 сая төгрөгийн камер суурилуулж, аймгийн Онцгой байдлын комиссоос 3500ш нэг удаагийн маск олгосоноос гадна Хүмүүн цогцолбор сургууль зохион байгуулалтын бэлтгэл ажлыг сайтар хангасан байна. Тус шалгалтад 3 сургуулийн 32 багш зохион байгуулагчаар, 51 багш нар хянагч багш хийж, давхардсан тоогоор 231 багш ажиллалаа.

Шалгалт авах 2 байрны 50 анги танхимуудад хяналтын камер суурилуулсан.

Шалгуулагчийн анхны оноог live.eec.mn болон БҮТ-ээс зөвшөөрөл авч аймгийн телевизээр засалтыг хязгаарлалтын нөхцөлтэйгээр шууд дамжуулж сум болон хөдөө орон нутагт эцэг эхчүүдэд нээлттэй хүргэлээ. Шалгалтын дэг зөрчсөн, сэдэв даалгавартай холбоотой болон халдвар хамгааллын дэглэм зөрчсөн зөрчил дутагдал илрээгүй. Цар тахлын өвчний сэжигтэй тохиолдол илрээгүй болно.

#### **Эрүүл ахуй халдвар хамгааллын чиглэлээр.**

2020 оны Элсэлтийн ерөнхий шалгалтын зохион байгуулалтад 07 сарын 02-05-ны өдрүүдэд элсэлтийн ерөнхий шалгалтыг зохион байгуулах үед коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх түр журам, МХЕГ-ын улсын ахлах байцаагчийн зөвлөмж, элсэлтийн ерөнхий шалгалтын явцад урьдчилан хяналтыг эрүүл ахуйн чиглэлийн 3 байцаагч хийж гүйцэтгэлээ.

Шалгалтын байрны үйл ажиллагааг хэвийн зохион байгуулах зорилгоор Хүмүүн цогцолбор сургуулийн багш ажилтан бусад шаардлагагүй хүмүүсийг оруулахгүй байх, шалгуулагч болон эцэг эхийг бөөгнөрөл үүсгэхгүй байхад анхаарч ЦГ, ОБГ, МХГ-ынхан хамтарч ажиллав.

Шалгалт авах 2 байрны 50 анги танхимуудад халдваргүйтгэл хийлгэж, 2 цаг тутам халдваргүйтгэлийн бодисын уусмалаар ширээ, сандал, хаалганы бариул, шалыг угаалгаж, агааржуулалт тогтмол хийлгэж, шалгалтын дараа тогтмол харандааг халдваргүйжүүлэх бодистой уусмалаар арчуулж ажилласан.

Шалгалтын үед халдвар хамгааллын дэглэм зөрчсөн зөрчил дутагдал илрээгүй. Цар тахлын өвчний сэжигтэй тохиолдол илрээгүй болно.

#### **Мал эмнэлгийн чиглэлээр:**

Төлөвлөгөөт шалгалтаар Цээл сумын Майхант уулын өвөр мал аж ахуйн гаралтай түүхий эд бэлтгэх газрыг 1.34 кодтой мал амьтны гаралтай түүхий эдийн хадгалалтыг шалгах хяналтын хуудасаар, Угтаалцайдам сумын Тэрэм төв мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, Мөнгөнморьт сумын Үржих гал, МЭГЕНЭ, Босго халдун мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийг 1.15.1 кодтой ерөнхий мэргэжлийн мал эмнэлгийн үйлчилгээг шалгах хуудсаар шалгаж, Цээл сумын Орлогын овоо цээл мал аж ахуйн гаралтай түүхий эд бэлтгэх газарт зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ. Зах зээлд нийлүүлж буй малын эм, тэжээлийн нэмэлтийн улсын бүртгэл, шинжилгээ баталгаажилтийн байдалд урьдчилан сэргийлэх шалгалтыг 4 сумын 7 малын эмийн санд хийж гүйцэтгэлээ.

Байгаль орчин, газар, геодези, зураг зүйн чиглэлээр Эрдэнэ суманд үйл ажиллагаа явуулж буй “Хаан жимс” ХХК, Сэргэлэн суманд үйл ажиллагаа явуулж буй “Монгол Алт” ХХК, “Электрком” ХХК-д төлөвлөгөөт шалгалт хийж Зөрчил дутагдал арилгуулахаар улсын байцаагчийн нийт 13 заалт бүхий 3 албан шаардлага хүргүүлж ажиллалаа.

**Хэмжил зүйн хяналтын чиглэлээр:** “Хөрс-Авто сервис” ХХК-ийн Аргалант суманд үйл ажиллагаа явуулж байгаа шатахуун түгээх станц, Баянхангай суманд үйл ажиллагаа явуулж байгаа “Магнай трейд” ХХК, “Ану сервис” ХХК-ийн Заамар сум дахь халаалтын зуух, Баянхангай, Аргалант сумын Эрүүл мэндийн төвд төлөвлөгөөт шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 18 заалт бүхий 3 албан шаардлага хүргүүлж ажиллалаа.

**Төлөвлөгөөт зөвлөн туслах үйлчилгээ:**

Байгаль орчин газар, геодези, зураг зүйн чиглэлээр Сэргэлэн суманд үйл ажиллагаа явуулж буй “Монгол ном” ХХК, “Цэцүүх трейд” ХХК-д төлөвлөгөөт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж улсын байцаагчийн 7 заалт бүхий 1 зөвлөмж, 5 заалт бүхий 1 албан шаардлага, Хэмжил зүйн хяналтын чиглэлээр: “Эл Си Би” ХХК-ийн Баянхангай сум дахь халаалтын зууханд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

**Төлөвлөгөөт бус шалгалт**

Тус газрын зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнууд харьяаллын дагуу шилжиж ирсэн 17 зөрчилд холбогдох иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 8,05 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан.

**Онцгой байдлын газрын хүрээнд:**

| №  | Төрөл                 | Мэдээний агуулга  | Хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ  |
|----|-----------------------|---|---|
| 1. | Ойн түймэр /мэдээлэл/ | Төв аймгийн Борнуур сумын Бичигт багийн "Сүжигт" гэдэг газарт /сумын төвөөс зүүн зүгт 30 км-т, Аймгийн төвөөс зүүн хойд зүгт 144 км-т/ ойн түймэр гарсан тухай дуудлагыг 2020.07.03-ны өдрийн 17:11 цагт хүлээн авсан.  | Тус сумын Хэсгийн төлөөлөгч цагдаагийн дэслэгч Г.Ган-Эрдэнээр ахлуулсан 5 хүн, 1 автомашин, алт олборлох "Харгана"-ны уурхайгаас 9 хүн, 2 автомашинтай ажиллаж байна. Нэмэлтээр 18:45 цагт сумын засаг дарга Б.Ууганбаяраар ахлуулсан 9 хүн, 3 автомашинтай. Нийт 23 хүн, 6 автомашинтай 19:12 цагт цурманд оруулан ажиллаж байна.  |
| 2. | Үер, усны осол        | Төв аймгийн Зуунмод сумын Зүүндэлгэр багийн "Баянбулаг" /1 дүгээр гудамжны 7 тоотоос иргэн Т.Энхтөрийн гэрийн хажуугаар/ /сумын төвөөс зүүн зүгт 3 км-т/ үерийн усанд Төв аймгийн Зуунмод сумын Зүүндэлгэр багийн 12 дугаар гудамжны 1 тоотод оршин суугч иргэн Н.Тогтохцэрэн /40 настай, эрэгтэй/ урсаж байна гэсэн дуудлагыг 2020.07.09-ны өдрийн 17:45 цагт хүлээн авсан.        | Тус аймгийн Онцгой байдлын газрын Эрэн хайх, аврах салбарын дарга ахлах дэслэгч З.Отгонзулаар ахлуулсан 6 алба хаагч, 1 автомашин ажиллаж иргэн Т.Энхтөрийн гэрээс баруун урагш 300 метрт эрэн хайх, аврах ажиллагаа явуулж нас барсан байдалтай олсон. 18:07 цагт Цагдаагийн мөрдөн байцаагч цагдаагийн ахмад С.Эрдэнэбилэгт шилжүүлэн өгсөн.  |
| 3. | Усны осол             | Төв аймгийн Лүн сумын Төв багийн "Модон гүүр" гэдэг газарт /сумын төвөөс зүүн хойд зүгт 7 км-т, Аймгийн төвөөс баруун зүгт 175км-т/ Улаанбаатар хотоос Хөвсгөл аймгийн чигт хөдөлгөөн үйлдэж явсан Э.Эрдэнэжаргал /31 настай, эрэгтэй/ Дорноговь аймгийн Замын-Үүд сумын харьяатай иргэн "Туул" голын усанд осолдсон гэсэн дуудлагыг 2020.07.11-ний өдрийн 14:15 цагт хүлээн авсан. | Тус аймгийн Онцгой байдлын газрын ЭХАСалбарын дарга ахлах дэслэгч З.Отгонзулаар ахлуулсан 3 алба хаагч, 1 автомашинтай 16:49 нэмэлтээр гарсан. Лүн суман дахь Эрэн хайх аврах бүлгийн Усчин-Аврагч дэд ахлагч Ө.Өлзиймөнхөөр ахлуулсан 4 алба хаагч, 1 автомашинтай, 1 завьтай, Тамгын газрын дарга Н.Даваахүүгээр ахлуулсан 2 цагдаагийн алба хаагч, 1 автомашинтай. Нийт 9 хүн, 3 автомашин, 1 завьтай эрэн хайх аврах ажиллагааг "Модон гүүр" гэдэг газраас "Улаан-Үзүүр" гэдэг газар хүртэл "Туул" голын усанд завьтай 7 км урсан /шумбалт хийгээгүй/, мөн голын эрэгээр 7 км явганаар эрэн хайх ажиллагаа явуулж 22:28 цагт осолдсон газар болох "Модон гүүр" гэдэг газраас буцалтгүй нэрвэгдэгчийг олж Лүн сумын хэсгийн төлөөлөгч цагдаагийн ахмад Б.Элбэгманлайд шилжүүлэн өгсөн. |
| 4. | Гал түймрийн мэдээлэл | Төв аймгийн Батсүмбэр сумын Мандал багийн "Үйлдвэрийн" 1 дүгээр гудамжны 9 тоотод иргэн Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 1 дүгээр хорооны "Богд ар"-ын 9-179 тоотод оршин суугч Ц.Гантулгын эзэмшлийн /25-28 УНГ/ улсын дугаартай "Хондо сивик" загварын автомашин шатаж байна гэсэн дуудлагыг 2020.07.12-ний өдрийн 13:13 цагт хүлээн авсан.                                     | Тус сумын удирдах албан тушаатантай холбогдох боломж хангаагүй сумын төвөөс баруун урд зүгт 25 км-т "Өртөөн мухар" гэдэг газар баяр наадмын хурдан морины уралдааны ажиллаж хэсэгт ажиллаж байсан тул биет холбоочин сум орон нутгийн иргэнийг явуулж мэдээ хүргүүлсэн. Автомашин бүрэн шатсан  |

|    |                      |  |  |
|----|----------------------|--|--|
| 5. | Усны осол            | Төв аймгийн Лүн сумын Өгөөмөр багийн "Том гүүр" гэдэг газарт /сумын төвөөс баруун зүгт 5 км-т, Аймгийн төвөөс баруун зүгт 175км-т/ иргэн Д.Баярмагнай /41 настай, эрэгтэй/ 85-27 УБЕ улсын дугаартай "Ниссан тийда" загварын автомашинаа "Туул" голын эрэг дээр үлдээсэн /Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 2 дугаар хорооны 59-1-16 тоотод оршин суугч/ усанд осолдсон байх магадлалтай гэсэн дуудлагыг 2020.07.13-ний өдрийн 07:37 цагт хүлээн авсан. | Тус сумын Эрэн хайх, аврах бүлгийн Усчин-аврагч аврагч Ө.Өлзиймөнхөөр ахлуулсан 4 алба хаагч, 1 автомашин, 1 завтай, сумын хэсгийн төлөөлөгч ахмад Б.Элбэгманлайгаар ахлуулсан 4 алба хаагч, 1 автомашин, Ар гэрээс 3 хүн, 1 автомашинтай. Нийт 11 хүн, 3 автомашин, 1 завтай эрэн хайх ажиллагааг эхэлсэн.  |
| 6. | Усны осол /мэдээлэл/ | Төв аймгийн Мөнгөнморьт сумын Жаргалант багийн "Хорихын амралт" гэдэг газарт /сумын төвөөс зүүн зүгт 14 км-т, Аймгийн төвөөс зүүн зүгт 195 км-т/ иргэн Энхбаярын Эрхэс /2 настай, эрэгтэй/ "Хэрлэн" голын усанд осолдсон тухай мэдээллийг 2020.07.14-ны өдрийн 14:10 цагт хүлээн авсан.  | Тус сумын Хэсгийн төлөөлөгч цагдаагийн дэслэгч Л.Ган-Эрдэнээр ахлуулсан 2 алба хаагч, 1 автомашинтай ажиллаж 15:38 цагт Хэсгийн төлөөлөгч цагдаагийн дэслэгч Л.Ган-Эрдэнэ цогцос байсан газар очин Э.Эрхэс мөн болох нь тогтоогдсон. Иргэн Ц.Даваадорж "Уу булан" амралтын газар /Сумын төвөөс зүүн урд зүгт 18 км-т/ 2 орчим настай хүүхдийн цогцос урсаж эргэ дээр гарч ирсэн гэсэн мэдээллийг 14:16 цагт өгсөн. |
| 7. | Объектын гал түймэр  | Төв аймгийн Сэргэлэн сумын Эрдэнэ-Уул багийн "Их булаг" гэдэг газарт Улаанбаатар хотоос Дорноговь аймгийн чиглэлд 34-87 УНТ "НОВО ТРИЛЭР" загварын ачааны автомашины /Төмөр болон түлш ачиж явсан/ дунд талын дугуйнаас гал гарч байна гэсэн дуудлагыг 2020.07.30-ны өдрийн 23:18 цагт хүлээн авсан.   | Тус аймгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 24 дүгээр ангийн салааны захирагч дэслэгч Б.Пүрэв-Очиороор ахлуулсан 6 алба хаагч, 1 автомашинтай ажиллаж унтраасан.   |
| 8. | Объектын гал түймэр  | Төв аймгийн Мөнгөнморьт сумын Байдлаг багийн "Цагаан толгой" гэдэг газарт /Сумын төвөөс урд зүгт 39 км-т, аймгийн төвөөс зүүн хойд зүгт 155 км-т/ иргэн Ж.Нямдоржийн эзэмшлийн 4ханатай монгол гэр бүрэн шатсан гэсэн мэдээллийг 2020.07.31-ний өдрийн 12:40 цагт хүлээн авсан.  | Тус сумын Хэсгийн төлөөлөгч дэслэгч Л.Ган-Эрдэнэ /80069453/ 1 автомашинтай мэдээллийн дагуу 12:50 цагт хөдөлсөн. Уг гал түймэрт бэртэж гэмтсэн хүн байхгүй.  |
| 9. | Объектын гал түймэр  | Төв аймгийн Зуунмод сумын Дэнж багийн 1 дүгээр байрны 3 тоотод оршин суух иргэн Л.Жаргалсайханы модон амбаар шатаж байна гэсэн дуудлагыг 2020.08.02-ны өдрийн 00:55 цагт хүлээн авсан.   | Тус аймгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах аврах 24 дүгээр ангийн 6 алба хаагч 1 автомашинтай 2 километр замыг туулан очиход иргэн Л.Жаргалсайханы 4х3 хэмжээтэй модон амбаар шатаж байсныг 600 литр ус зарцуулж бүрэн унтраасан. Уг гал түймэрт гэмтэж бэртсэн хүн байхгүй  |



|     |                                       |  |   |
|-----|---------------------------------------|--|---|
| 10. | Эрэн хайх аврах ажиллагаа /Усны осол/ | Төв аймгийн Эрдэнэсант сумын Угалзат багийн "Жаргалант" гэдэг газарт /сумын төвөөс баруун урд зүгт 45 км-т/ "Ботгоны гол"-ын ойролцоо хонь хариулж явсан /Сандагдорж овогтой Сумъябазар 13 настай эрэгтэй, Сандаг-Очир овогтой Шинэбаяр 13 настай эрэгтэй / нар голын усруу орж живж нас барсан тухай мэдээг тус сумын 2020.07.22-ны өдрийн 19:25 цагт хүлээн авсан. | Тус сумын Цагдаа Н.Саруулмөнх, Багийн дарга А.Гантулга, сумын их эмч Д.Бат-Очир 1 автомашинтай 17:21 цагт сумаас гарч 18:10 цагт очиж голын усанд живсэн 2 хүүхдийн цогцсыг голын усанд хөвж байсныг гаргаж авсан тухай мэдээг 19:25 цагт ЗДТГ-ын дарга С.Сарантуяа 96655605 дугаарын утсаар мэдээ өгсөн. |
|-----|---------------------------------------|--|---|

### **Гурав. Хууль, эрх зүйн хэлтсийн хүрээнд:**

#### **Удирдлага зохион байгуулалтын хүрээнд:**

ХЗДХЯ, ХЗС-тай хамтран Зууны мэдээ сонины 7 хоног тутмын “Хуульч зөвлөж байна” асуулт хариултын буланд 4 дугаарыг шинэ хуулиудийн сэдвээр, Монголын радиогийн сар тутмын “Хуулийн цаг” зохиомжит нэвтрүүлгийн 07 сарын дугаарыг “Зөрчлийн тухай хууль”-ийн сэдвээр тус тус бэлтгэн нийтэд хүргэлээ.

Аймаг, сум, байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудын 29 шийдвэр, гэрээний хууль зүйн үндэслэлийг хянаж, зөвлөмж өгч, хууль, эрх зүйн асуудлаар нийт 32 иргэн болон сумд, байгууллагуудад зөвлөгөө, мэдээлэл, лавлагаа, эрх зүйн туслалцаа үзүүлж, Дотоод удирдлагын системээр шинэ хууль тогтоомжийн 13 мэдээлэл оруулж, төрийн албан хаагчдыг хууль, эрх зүйн мэдээ мэдээллээр хангаж ажиллалаа.

Аймгийн Захиргааны хэргийн шүүх, Иргэний хэргийн шүүхэд аймгийн Засаг даргыг төлөөлж 5 хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож тайлбар дүгнэлт гаргаж, 4 шүүх хуралдаанд оролцсон.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2-р хуралдааныг 2020 оны 07 дугаар сарын 08-ний өдөр хуралдаж 3 асуудал хэлэлцэж сум, байгууллагад үүрэг чиглэл өглөө. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2018 оны 05/06 дугаар зөвлөмжийн 1.6, Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоолоор баталсан Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд цагдаагийн ерөнхий газрын даргын баталсан 2020 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн баталсан удирдамж, төлөвлөгөө хүрэнэд салбар төлөвлөгөө гаргаж “Устгал” нэгдсэн арга хэмжээг хогийн олсны ургамал /каннабис/-ын тархац тогтоогдсон Сүмбэр, Жаргалант, Борнуур, Баянчандмань, Батсүмбэр сумдын нутаг дэвсгэрт зохион байгуулсан.

#### **Архивын тасгийн чиглэлээр:**

1. Архивын тасгаас төрийн архивын эх баримтаас үйлчилгээ үзүүлэх зорилгоор энэ сард 177 иргэний хүсэлтийг хүлээн авч 447 хуулбар хувь, 110 лавлагаа, 192 хөмрөгийн 785 хадгаламжийн нэгжийн баримтыг ашиглан лавлагаа мэдээллээр үйлчилгээ үзүүлэн ажиллав.

2. Архивын баримтаас 4 хөмрөгийн 73 хадгаламжийн нэгжийн 7137 хуудас баримтын 33715 хүний нэр, 6470 заалтын тоо, 6470 тушаалын тоог мэдээллийг програмд хадгаламжийн нэгжийн түвшинд шивж, 4 хөмрөгийн 73 хадгаламжийн нэгжийн 7274 хуудас баримт скайнердаж, 6470 заалтыг PDF.JPEG хэлбэрт хувиргаж, 6470 заалтын 7274 хуудас баримтыг өгөгдлийн сантай холбож цахим бааз үүсгэлээ.

3. Тасгийн үйл ажиллагаанаас 1,317,000 төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлэн өөрийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх бичгийн цаас, баримтын хавтас, хайрцаг, утас, цаас техник хэрэгсэл зэргийг архивын өөрийн орлогоос зарцуулж шийдвэрлүүлэн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

#### **Улсын бүртгэлийн чиглэлээр:**

##### **1.Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:**

2020 оны 07-р сарын байдлаар цахим санд нийт 56,619 хувийн хэрэг байгаагаас Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 10,187, Газар өмчлөх эрхийн 46,416 байна. Нийт хүлээн авсан мэдүүлэг 10,662.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Засгийн газрын 2010 оны 237 дугаар тогтоолын дагуу үйлчилгээний хураамжийн орлогоос нийт төгрөгийг 108,772,088, үл хөдлөх худалдан борлуулсны 91,556,320, тэмдэгтийн хураамжаас 3,245,930 төгрөгийг тус тус улсын төсөвт орууллаа.

## 2.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр:

Тайлангийн хугацаанд нийт 161 аж ахуй нэгж байгууллага бүртгүүлснээс 59 нэмэлт өөрчлөлт, шинээр 102 хуулийн этгээд үүсэн байгуулагдаж татан буугдсан хуулийн этгээд 3 хийгдсэн байна..

Тайлангийн хугацаанд хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сангаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 0 лавлагаа, хууль хяналтын байгууллагад 0 лавлагаа, иргэнд 0 лавлагаа тус тус өгсөн.

Хуулийн этгээдийн бүртгэлийн тэмдэгтийн хураамжийн орлого 6,366,000 төгрөгийг орон нутгийн төсөвт орууллаа.

## Цагдаагийн газрын үйл ажиллагааны чиглэлээр:

Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 2020 оны эхний 7-н сарын 25-ны өдрийн байдлаар нийт 492 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19 хэргээр буюу -3.7 хувиар буурсан, хөнгөн гэмт хэрэг 422 бүртгэгдсэн нь 10 нэгжээр буюу 2,8 хувиар өссөн, хэрэг бүртгэлтийн гэмт хэрэг 407 бүртгэгдэж 25 нэгжээр буюу -5,7 хувиар буурсан, мөрдөн байцаалтын гэмт хэрэг 85 бүртгэгдсэн нь 6 нэгжээр буюу 7,5 хувиар өссөн, хүнд гэмт хэрэг 70 бүртгэгдэн өмнөх оны мөн үетэй харьцуулахад 29 нэгжээр буюу -41,4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн илрүүлэлт 41 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2,6 хувиар өссөн.

## Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны үйл ажиллагаа:

Эрүүлжүүлэх, саатуулах байранд гудамж талбай олон нийтийн газар ухаангүй унасан, ар гэртээ согтуугаар танхайрсан зөрчил гарган эрүүлжүүлэгдсэн -37, шүүхээр баривчлагдсан-46, албадан саатуулагдсан-13, ар гэрт нь хүлээлгэн өгсөн-15 нийт 111 иргэнийг эрүүлжүүлэх саатуулах байранд код журмын дагуу биед болон эрүүл мэндийн үзлэг хийж хүлээн авч авч ажилласан.

Эрүүлжүүлэгдсэн 37 иргэдээс төлбөр болох 153550 төгрөг, хугацаа дууссан 40 хүмүүжигчийн төлбөр 1387000 төгрөг нийт төрийн сангийн дансанд 13646700 төгрөгийг тушаалгаж, 07 сарын байдлаар баривчлагдсан иргэдээс төрийн санд тушаасан төлбөр төлөлт 96,1% байна

## Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

Төв аймгийн болон 27 сумын баяр наадам 2020 оны 07 дугаар сарын 10-аас 13-ны хооронд зохион байгуулагдахад цагдаагийн газрын 212 алба хаагч үүрэг гүйцэтгэж хамгаалалтыг осол, зөрчилгүй зохион байгуулсан.

Шүүх хурлын 1,2,3-р танхимуудад 1041 оролцогчтой Эрүүгийн хэргийн 138, Иргэний хэргийн 69, Захиргааны 7, Хянан магадлангийн-9 нийт 223 шүүх хуралдаанд журам сахиулсан.

Мөнгөнморьт суманд байрлах ШШГЕГ-ын харьяа хорих 415, 417-р ангид хянан магадлангийн 44 оролцогчтой нийт эрүүгийн 9 шүүх хуралдаанд журам сахиулж шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангаж ажилласан.

Хуяглан хүргэх ажиллагаа бүрт төлөвлөгөө, зураглал гаргаж Цагдаагийн газрын даргаар батлуулан Төв аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Цагдан хорих байрнаас 9 шүүгдэгчийг хүлээн авч биед нь үзлэг хийж, тэмдэглэл үйлдэж, шүүхэд хуяглан хүргэж, шүүх хуралдаанд оролцуулан буцааж Шүүхээс 16 шүүгдэгч, яллагдагчийг Төв аймаг дахь Цагдан хорих байранд хуяглан хүргэж ерөнхий жижүүрт нь хүлээлгэн өгч аюулгүй байдлыг хангаж ажилласан.

Улаанбаатар хот хорих 461-р ангиас 1 шүүгдэгчийг шүүхэд хуяглан хүргэж шүүх хуралдаанд оролцуулан буцааж хуяглан хүргэж ажилласан.

## Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон 65 жолоочийг илрүүлж, 57 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хасаж, 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэж тээврийн хэрэгсэл жолоодон хөдөлгөөнд оролцсон 8 иргэнийг Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэврээр баривчлуулж Цагдаагийн ерөнхий газрын нэгдсэн санд мэдээллийг бүртгэж ажилласан.

Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 3443 жолоочийг 112,480.000 / нэг зуун арван хоёр сая дөрвөн зуун наян мянга/ төгрөгийн торгууль оногдуулж, зөрчил гаргасан 43 жолоочийн тээврийн хэрэгслийг түр саатуулсан.

## Шүүхийн шинжилгээний албаны үйл ажиллагааны чиглэлээр:

Энэ сард Криминалистикийн шинжилгээ-101, Нийт хийсэн магадлан шинжилгээ-120, Хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ул мөр-384, гарын мөрийн санг баяжуулсан-216, гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийн дүгнэлт 449 гаргасан.

## Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үйл ажиллагааны чиглэлээр:

| Шийдвэр<br>гүйцэтгэлийн<br>бодит биелэлт | Оны<br>эхний<br>үлдэгдэл | Шинээр<br>нэмэгдсэн | Хасагдсан | Биелүүлбэл<br>зохиох | Бодитой<br>биелүүлсэн | Үлдэгдэл  | Дундаж<br>хувь |
|--|--------------------------|---------------------|-----------|----------------------|-----------------------|-----------|----------------|
| 07-р<br>сар                              | 321                      | 236                 | 27        | 530                  | 242                   | 288       | 45.6%          |
|  | 4335531,9                | 1515540,4           | 913340,3  | 4937732,0            | 1037897,1             | 3899834,9 |                |

**Дөрөв. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн хүрээнд:**

**Хүнс, хөдөө аж ахуйн салбарын чиглэлээр:**

*Газар тариалангийн талаар:*

2020 онд үр тариа 67362 га-д тариалахаас зорилтыг 65.74%, төмс-10762 га буюу 137.7%, тэжээл-23471 га буюу 204.1% хүнсний ногоо 1540.9га буюу 96.3%, тосны ургамал 17212га буюу 163.9% д тус тус тариалалт хийгдэж нийт 124416 га-д тариалахаас 120348 га-д тарьж 96.7%-ийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс усалгаатай тариалан 4000 га-д хийгдэж, өмнөх оноос 150 га-аар нэмэгдсэн.

Уриншинд шаардлагатай түлш шатахуун, хор гербицидийн мэдээллийг сум бүрээс аж ахуй нэгжээр гаргаж, 13 сумын 294 иргэн, аж ахуйн нэгж 96655.2 га-д уринш хийх захиалгыг Хөдөө аж ахуйг дэмжих санд уламжилж нийлүүлэлтийг цаг хугацаанд нь зохион байгуулж байна. 2020.07.27-ны байдлаар 11 сумын 8300 га-д химийн уринш, 2924 га-д механик уринш хийгдлээ.

Намрын ургац хураалтад 6 сумын 53 иргэн аж ахуйн нэгжид 1236 хүн ажиллах тооцоо гарган захиалгыг авч ХХААХҮЯ-амнд хүргүүлээ.

Газар тариалангийн үйлдвэрлэлийн 2020 оны судалгаанаас хоцорсон 3 сумын 143 иргэн аж ахуйн нэгжийн судалгааг нөхөн бүрдүүлж ХХААХҮЯ-нд хүргүүлээ.

*Мал аж ахуйн талаар:*

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны 06 сарын 17-ны А/218 дугаар тушаалаар сүү-махны чиглэлийн хосолмол ашиг шимт “БУГАН ХАЛИУН” үүлдрийн хэсгийн үхрийг Монгол улсад шинээр зохион бүтээсэн мал, амьтны улсын бүртгэлд бүртгэж баталгаажуулан ГЭРЧИЛГЭЭ олгов.

Аймгийн баяр наадмыг зохион байгуулах Засг даргын А/358 дугаар захирамжаар байгуулагдсан Хурдан морины салбар хорооны ажлын хэсэгт ажиллан нийт 6 насны 399 морины үүлдэрлэг байдлыг тогтоон ажиллав.

Мал бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн программ хангамжийн сургалтыг хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүдэд үе шаттайгаар зохион байгуулж, 13 сумын мэргэжилтнүүдийг хамрууллаа.

Мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах, нөхөн тавих хээлтүүлэгч болон өнжөөх төлүүлэх хээлтүүлэгчийн судалгааг гарган мэдээг ХХААХҮЯ-нд хүргүүлсэн. Одоогийн байдлаар хуц-58, ухна-61, бух-37 толгойг нөхөн тавьсан.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2020 онд нийт 26 суманд 39 худаг шинээр гаргахаас Баян ус ХХК нь 8 худгаас 7 худаг гаргаж, Виктор ус ХХК нь 9 худаг гаргахаас 5 худаг гаргаж, Golden Hill ХХК нь 22 худгийн хайгуулын ажил хийгдсэн. Ажлын гүйцэтгэл 57.5 хувьтай байна.

*Үйлдвэрлэл, үйлчилгээний талаар:*

Засгийн газрын 2020.03.25-ны өдрийн 113-р тогтоолоор батлагдсан “Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас хөнгөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу ЖДҮХСангаас олгох хөнгөлөлттэй зээл хүссэн 44 аж ахуй нэгжийн төслийг хүлээн авч төслийн иж бүрдэл хангах 1 дүгээр шатны шалгаруулалтад 22 аж ахуй нэгжийн төсөл буцаагдаж, 2.6 тэр бум төгрөгийн 22 аж ахуй нэгжийн төсөлд урьдчилсан шатны судалгаа хийгдэж, 17 төсөл дараагийн шатанд шилжсэн.

Эхний 7 сарын байдлаар Сум хөгжүүлэх сангаас 13 сумын 100 төсөлд 754.9 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг олгож, боловсруулах салбарын үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 3.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн.

Аймгийн баяр наадмаар нийтийн хоолны үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгж, иргэдэд “Хүнсний аюулгүй байдал, үйлчилгээний чанар, галын аюулгүй байдал, хоггүй цэвэрхэн наадах” чиглэлээр ОБГ, МХГ, СХЗХ-тэй хамтран сургалт зохион байгуулж зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллав.

“Нийгмийн түншлэлийн сүлжээ ТББ”-тай хамтран “Бизнэсээ эхэл-Бизнэсээ хөгжүүл” сэдэвт сургалтыг зохион байгуулж 6 сумын 6 хүнс, жижиг дунд, хоршоо хариуцсан мэргэжилтэн, 12 үйлдвэр эрхлэгч иргэд оролцсон.

***Малын эрүүл мэндийн чиглэлээр:***

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1803.6 мян/мал хамруулахаар Биокомбинат УТҮГ-тай гэрээ байгуулж, вакцины нийлүүлэлт 95.6%, вакцинжуулалт 81.04 хувьтай явагдаж байна.

Аймгийн Засаг даргын А/286 тоот захирамжийн дагуу гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын төлөвлөгөөт дархлаажуулалтын ажлыг Мөнгөнморьт, Баян, Зуунмод, Баяндэлгэр, Баянжаргалан, Архуст, Эрдэнэ сумдад эхлүүлж 97%-тай дууслаа.

Ерөнхий сайдын 01 албан даалгаврын хэрэгжилтийг хангахаар Аймгийн Засаг даргын 2020.02.20-ны өдрийн А/119 дугаар захирамжаар сэг зэм устгал, халдваргүйтгэлийн ажлыг 27 суманд зохион байгуулж, нийт 71370 малын сэг зэмийг булж, шатааж устган 58.2 мян/м2 талбайд халдваргүйтгэл хийж 100.9 хувьтай хэрэгжиж дууслаа.

Энэ онд 1265.0 мян/м2 талбайд халдваргүйтгэл хийхээр төлөвлөснөөс 881 хашаа хорооны 616.1 мян/м2, 988 худаг уст цэгийн 60.2 мян/м2, Бэлчээр-27.7 мян/м2, 84 агуулах зоорийн 44.1 мян/м2, 48 устгалын цэгийн 58.2 мян/м2 нийтийн эзэмшил зам талбайн 237.5 мян/м2, нийт 1043.8 мян/м2 талбайд халдваргүйтгэл хийж 82.5 хувьтай байна.

Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэхээр Мал угаалгын ажилд 4604.1 мян/толгой мал хамруулахаас 414,3 мян/толгой мал хамруулж, ажлын явц 9%-тай явагдаж байна.

Мал эмнэлгийн нэгдсэн системээр 10010 цахим гэрчилгээ олгож, 1583 дуудлагын дагуу үйлчилгээ үзүүлээ.

Лүн суман дахь Мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэгээр мал амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн тээвэрлэн буй 2202 тээврийн хэрэгсэл, тэмээ 228, адуу 2769, үхэр 2946, хонь 27616, ямаа 7065 толгой мал, мах, махан бүтээгдэхүүн 1337.93тн, арьс шир 125508 ширхэг, ноос 274тн ноолуур 388,4 тн, дайвар-11814,5 ш, цагаан идээ-13,6 тн бүтээгдэхүүний эрүүл ахуй, мал эмнэлгийн гэрчилгээнд хяналт шалгалт хийсэн.

Лабораторийн шинжилгээнд ийлдэс судлалын 420 дээжинд бруцеллөз, лейкоз, сүрьеэ өвчний тандах шинжилгээг хийхэд сөрөг, Нян судлалын 13 дээжинд Цусан халдвар, ДХХ, Энтеробактериоз Листерииозийн шинжилгээ хийхэд Зуунмод сумын дээжинд Энтеробактериоз үүсгэгч эерэг, Ариун цэврийн шинжилгээнд 25 худалдааны цэг, иргэнээс 43 мах, сүүний дээж авч антибиотекийн үлдэгдэл, бруцеллөзын шинжилгээ хийхэд бүгд сөрөг урвал үзүүлэв.

***Стандарт хэмжил зүйн чиглэлээр:***

2020 оны 07 сарын байдлаар Зуунмод, Баянчандмань, Эрдэнэ, Эрдэнэсант, Өндөрширээт сумдад ажиллан Тохирлын гэрчилгээ шинээр авах буюу сунгуулахаар хүсэлт ирүүлсэн 49 /амралт жуулчны бааз-3, Худалдаа-38, Нийтийн хоол-8/ бүтээгдэхүүн, үйлчилгээнд тохирлын үнэлгээ хийж, эхний 7 сарын байдлаар 183 бүтээгдэхүүн, үйлчилгээнд тохирлын гэрчилгээ олголоо.

Хэмжил зүйн лабораторийн массын лабораториор Зуунмод, Эрдэнэсант, Өндөрширээт сумын 31 ААН, иргэдийн худалдаа үйлчилгээ, мөнгөн тооцоонд ашиглаж байгаа нийт 67ш массын хэмжих хэрэгсэл шалгаж баталгаажууллаа.

Эзэлхүүн зарцуулалтын лабораториор “Жаст Ойл” ХХК, “Магнай трейд” ХХК, “МТ Наран төгрөг” ХХК, “Тэс Петролиум” ХХК-ний аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 31 ШТС-ын хэмжих хэрэгслүүдэд улсын I-р ээлжит баталгаажуулалтыг хийж, хэмжих хэрэгслийг шалгаж баталгаажуулсан.

***Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны чиглэлээр:***

Аймгийн ТЭЗахирагчийн 2020 оны хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг төрийн худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn), [www.Khural.mn](http://www.Khural.mn) сайт “Өдрийн сонин”-ны 2020.01.07-ны №003 (6369)-т “Монголын үнэн” сонины 2020.01.08-ны №003-т тус тус нийтлүүлж мэдээллийн ил тод байдлыг хангаж ажилласан.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 39,678.8 сая төгрөгийн 103 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 36,780.1 сая төгрөгийн 82 төсөл, арга хэмжээнд тендер зарлаж хэрэгжүүлэхээс өссөн дүнгээр 78 төсөл, арга хэмжээнд үнэлгээний хороог байгуулж, цахим тендер шалгаруулалтыг зохион байгуулан хэрэгжилт 95.12 хувьтай байна. Мөн үнэлгээний хорооноос захиалагч байгууллагад нийт 31,104.4 сая төгрөгийн 64 төсөл, арга хэмжээний гэрээг байгуулах шийдвэр хүргүүлснээс 27,566.0 сая төгрөгийн 53 төсөл, арга хэмжээнд гэрээ байгууллаа.

7-р сарын байдлаар тендерийн шатанд байгаа төсөл, арга хэмжээ

Тендер зарлагдсан төсөл, арга хэмжээ

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 1,024.8 сая төгрөгийн 2 ажил  
Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийн 180.0 сая төгрөгийн 1 ажил  
Аймгийн төсвийн шилжих үлдэгдлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 630.0 сая төгрөгийн 2 ажил  
Үнэлгээний хорооноос тендерийн баримт бичиг боловсруулж буй төсөл, арга хэмжээ  
Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2,504.2 сая төгрөгийн 1 ажил  
Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын 158.5 сая төгрөгийн 2 ажил  
Аймгийн Замын сангийн хөрөнгө оруулалтын 255.0 сая төгрөгийн 1 ажил  
Аймгийн төсвийн шилжих үлдэгдэлийн 120.0 сая төгрөгийн 2 ажил  
Үнэлгээний хорооноос захиалагч байгууллагуудад нийт гэрээ байгуулах дүгнэлт хүргүүлсэн төсөл, арга хэмжээ-гэрээ хийгдэхээр хүлээгдэж буй ажил  
Аймгийн ОНХСангийн хөрөнгөөр хийгдэх 1,660.0 сая төгрөгийн 4 ажил  
Аймгийн БХНСАХЗардлын хөрөнгөөр хийгдэх 264.9 сая төгрөгийн 6 ажил  
Аймгийн шилжих үлдэгдлийн хөрөнгөөр хийгдэх 200.0 сая төгрөгийн 1 ажил

### **Орон нутгийн өмчийн чиглэлээр:**

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмчлөлд байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтэглээрээ анхны үнийг нөхсөн, нөхөөгүй боловч эвдэрсэн хөрөнгийг засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох асуудлыг ИТХТ-н хурлаар хэлэлцүүлэн “Эрх шилжүүлэх тухай” 52 дугаар тогтоолоор батлуулж, үний дагуу Засаг даргын 07 сарын 20-ны өдрийн А/396 дугаар захирамжаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаа.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол, Засаг даргын захирамжийн дагуу тэг өртөгтэй хөрөнгийг шийдвэрлүүлэхээр Цагдаагийн газар, Баянчандмань Политехник коллеж, Заамар сумын цэцэрлэг, Дэгдээхий цэцэрлэг, Бүжинхэн цэцэрлэг ирүүлсэнээс Дэгдээхий, Бүжинхэн цэцэрлэгийн материал дутуу тул дахин ирүүлэхээр буцаагдаж, бусад байгууллагын хөрөнгийг судалж байна.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хөрөнгө шийдвэрлүүлэх /Зуунмод мах боловсруулах үйлдвэрийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн үнийг 30%-иар бууруулахаар, Баянчандмань сумын хуучин засварын төвийн барилгын худалдах доод үнийг тогтоон дуудлагын худалдаагаар худалдахаар/ асуудлыг нэгтгэн танилцуулж шийдвэрлүүлээ.

### **Барилга, хот байгуулалтын чиглэлээр:**

Барилга хот байгуулалтын сайд Мөнхбаатараар ахлуулсан БХБЯ-ны удирдлагууд, ГЗБГЗЗГ-ын дарга удирдлагууд, БХТ-ийн дарга удирдлагууд хот төлөвлөгч, мэргэжлийн байгууллагуудын нэгдсэн ажлын хэсэг 2020.07.27-нд Төв аймгийн Зуунмод хот, Сэргэлэн суман дахь Шинэ Зуунмод хот, Майдар хотуудын төлөвлөлт өнөөгийн байдалтай газар дээр ирж танилцан ажлын хэсгээс цаашдын төлөвлөлт, хоорондын уялдаа түүний дэд бүтэц, эх үүсвэр хангамжийг нэгдсэн бодлого төлөвлөлт боловсруулахаар шийдвэрийг гаргалаа.

Архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулах баталгаажуулах ажлын хүрээнд нийт 2020 онд 50 архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулан батлаад байна. Энэ сард 14 архитектур төлөвлөлтийн даалгавар олгосон.

Зураг төсөл зөвшөөрөлцөх баталгаажуулах шатанд байршилыг ерөнхий төлөвлөгөөний хүрээнд батлах, орон нутгийн саналыг зурагт тусгах зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн. 2020 онд 56 зураг төсөл зөвшөөрөлцсөн. 07-р сард 23 зураг төсөл батлаад байна.

Засгийн газрын 2018 оны 68, 171 тоот тогтоолын хүрээнд аймгийн хэмжээнд 46 барилга байгууламжийн эхлүүлэх зөвшөөрөл олгов. Энэ сард манайд 9 барилга байгууламжид барилга эхлүүлэх зөвшөөрөл олгогдсон.

Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн хүрээнд нийт 31-н барилга байгууламжид комисс ажиллан үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулсан байна. Энэ сард 6 барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулсан байна.

Иргэн аж ахуйн нэгжээс барилга байгууламжийг ашиглалтад оруулах зөвшөөрөл хүссэн 2 материал ирүүлж, хянагдаж байна.

### **Газрын харилцааны чиглэлээр:**

“Байгалийн гамшигт үзэгдэл, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор Зуунмод сумын нутаг дэвсгэрт голын ай, сав дагуу оршин суудаг айл өрхүүдийг нүүлгэн шилжүүлэх, газрын байршлыг өөрчлөх санал боловсруулах” Аймгийн засаг даргын 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/380 тоот “Ажлын хэсэг байгуулах тухай” захирамжийн дагуу Баянхошуу баг, Нацагдорж баг, Зүүндэлгэр багын үерт өртсөн айл өрхүүдийн зарим иргэдтэй газар дээр нь очиж ажиллан нарийвчилсан

судалгааг гарган яаралтай шилжүүлэх шаардлагатай Баянхошуу багт 9, Нацагдорж 5-р баг 4 иргэний газрын кадастрыг хийж газрыг зааж баталгаажуулж өгсөн.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, Хөдөө аж ахуйн байгууллага болон тус газрын хооронд 2019 оны 2019/92 дугаартай хамтран ажиллах гэрээнд заасан “Үндэсний хэмжээний газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлтийн үнэлгээ” хийх ажлын хүрээнд одоогийн байдлаар 500 цэгийн үнэлж, мэдээллийг хадгалаад байна.

Газрын төлбөрийн чиглэлээр: Газрын төлбөр: 2020 оны 7 дугаар сарын байдлаар газрын төлбөрийн орлого 1,691,666.6 мянган төгрөг төвлөрүүлэхээс 1,667,576.0 мянган төгрөгийг төвлөрүүлж 98.5%-ийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс 271,357.1 мянган төгрөг дутуу төлөлтөөс, 373,748.5 мянган төгрөг дуудлага худалдаанаас төвлөрсөн.

Аймгийн хэмжээнд 25 сумын 333 нэгж талбарт дуудлага худалдааг зохион байгуулахаар төлөвлөсөн. Үүнээс 12 сумын 275 нэгж талбарт дуудлага худалдааг зохион байгуулсан.

### **Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр:**

#### ***Аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлын талаар:***

“Хонины найр эвент 2020”-Төв аймаг Алтанбулаг сум Аргал багийн Баянсонгинот малчны бүлэгт 7 дугаар сарын 25-ны өдөр Монголчуудын уламжлалт зан үйл, ахуй соёлыг жуулчид болон дотоодын аялагчдад сурталчлан таниулах зорилготой “Хонины найр” эвент 6 дахь удаагаа амжилттай зохион байгуулагдлаа.

Арга хэмжээнд Монголд суугаа Америкийн элчин сайдын яам, Монцамэ агентлагийн Япончууд, Солонгосын элчин сайдын яам, БОАЖЯам, Аялал жуулчлалын үндэсний төв, Монголын аялал жуулчлалын холбоо, Join.me, Mongolian trekking тур компанийн төлөөлөл гэх мэт 130 гаруй зочид төлөөлөгчид хүрэлцэн ирсэн өргөн хүрээний арга хэмжээнд цэвэрхэн, хоггүй байгальд ээльтэй эвентийг зохион байгууллаа.

#### ***Ойн бодлогын талаар:***

Эрдэнэ сумын ойн санд, ойн хортонтой тэмцэх ажлыг зохион байгуулах БОАЖГ-ын даргын 04 сарын 10-ны А/47 дугаар тушаалаар "Ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах" ажлын хэсэг байгуулагдсан. Техникийн тодорхойлолтыг боловсруулан ААН-үүдэд урилга хүргүүлсэн. ААН-ээс ирүүлсэн материалыг ажлын хэсэг судлаад Мөнхногоон-Ой ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Мөнхногоон-Ой ХХК гэрээний дагуу тэмцлийн ажлаа хийж дуусаад 07 сарын 08-ны өдөр 92 хувийн гүйцэтгэлтэйгээр ажлаа хүлээлгэн өгсөн.

Аймгийн “Ойн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г 2017-2020 онд хэрэгжүүлж, хэрэгжилтийг 07 сарын 21-нд Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 22-нд ИТХТ-ийн хуралд өргөн барьж 92 хувь буюу 4,6 оноотой бүрэн хэрэгжүүлсэн гэж дүгнүүллээ.

#### ***Орчны бохирдлын талаар:***

Тулгар төрийн 2229, Их Монгол Улс байгуулагдсаны 814, Ардын хувьсгалын 99 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан “Ногоон Паспорт” санаачилгын хүрээнд “Цэвэрхэн наадацгаая” аяныг 3 дахь жилдээ хэрэгжүүлэн ажиллаа. Тус аяны хүрээнд үндэсний их баяр наадмын тасалбар болон автомашины тусгай зөвшөөрөл дээр “Цэвэрхэн наадацгаая” уриалгыг хэвлүүлэх, нийтийн хоолны зөвшөөрөл хүсэгчдэд гялгар уутнаас татгалзаж, хүнсний цаасан баглаа, боодол ашиглах шаардлага хүргүүлж, наадмын талбайд 3\*5 метр хэмжээтэй мөн үйлчилгээний гэр, цэгүүдэд 50\*60 см хэмжээтэйгээр “Цэвэрхэн наадацгаая” уриаг хэвлэн байршуулж ард иргэдийг уриалах, мөн нийтийн цэвэрлэгээг өргөн хүрээтэй зохион байгуулах зэрэг ажлыг өрнүүлж цэвэрхэн сайхан наадлаа. Аяны хүрээнд 138 албан байгууллагын 2245 иргэдийн оролцоотой 550,9 тн хог хаягдалыг цэвэрлэж энэ ажилд нийт 1,2 сая төгрөгийг зарцууллаа.

#### ***Хяналт шалгалтаар:***

Сэргэлэн, Батсүмбэр суманд үйл ажиллагаа явуулж буй амралт, аялал жуулчлалын газар, ус ашиглагчдын үйл ажиллагаанд зөвлөн туслахаар ажиллав.

2020 оны 07сарын 02-ны өдрийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын даргын баталсан удирдамжын дагуу, Сэргэлэн сумын 8 ААН, Батсүмбэр сумын 11 ААН хамрагдав. Мөн аймгийн аялал жуулчлалын холбооны тэргүүн Л.Оюунбилэг хамт явж холбооны үйл ажиллагааг танилцуулан, холбоонд элсэхийг уриалж ажиллав. Тус ажлын хүрээнд сумын байцаагч бичиг баримтын бүрдлийг хянан, зарим ААН-д хугацаатай албан даалгаврыг гаргаж өгсөн.

Хяналт шалгалтын үеэр Сэргэлэн сумын ихэнхи ААН корона вирусын улмаас амрагч хүлээн авч чадаагүй, Батсүмбэр сумын амралтын газрууд наадмын үеэр амрагчид хүлээн авсан бусад үед хүн цөөхөн байгаагаа хэлж байв.

### **Ус, цаг уур, орчны шинжилгээний чиглэлээр:**

*Урьдчилан мэдээлэх талаар:*

Нарийвчилсан мэдээ, 1, 5, 7 хоногийн мэдээ, сарын болон улирлын мэдээ, өнгөрсөн 1 болон 7, 10 хоног тутмын цаг агаарын тойм мэдээг тус тус гаргаж, И-мэйл-ээр дамжуулж, [www.tuv.tsag-agaar.gov.mn](http://www.tuv.tsag-agaar.gov.mn) сайтад байршуулан, өдөр тутмын цаг агаарын мэдээг Зуунмод сумын ОНИМ-ийн ажилтанд И-мэйл ба “Дотоод удирдлагын систем”-ээр явуулах ажил тасралтгүй хийгдэж, төв талбай болон байгууллагын урсдаг гэрлэн самбарт нарийвчилсан, хоногийн мэдээг өдөр бүр байршуулан ард иргэдэд үйлчилж байна. Мөн Дотоод удирдлагын систем, И-мэйл хаяг, [www.tuv.tsag-agaar.gov.mn](http://www.tuv.tsag-agaar.gov.mn) сайтад, TuvTsagiur page-д байршуулан нийт хэрэглэгчдэд хүргэж үйлчиллээ. 07 дугаар сарын 08, 08, 24-нд ихэнх нутгаар их борооны сэрэмжлүүлэх мэдээ, 07 дугаар сарын 07, 15-ны өдрүүдэд дуу цахилгаантай усархаг аадар бороо орох тул, гэнэтийн үер ус, нөөлөг салхины аюулаас сэрэмжтэй байхыг онцгойлон анхааруулсан мэдээг 12-48 цагийн өмнө [www.tuv.tsag-agaar.gov.mn](http://www.tuv.tsag-agaar.gov.mn) сайтад, TuvTsagiur page-д, Дотоод удирдлагын системийн олон нийтийн цэсэнд байршуулан мөн давхардсан тоогоор 9430-н хэрэглэгч /малчид, ард иргэд/-ийн гар утсанд Багц мессежээр хүргэж үйлчиллээ.

*Байгаль орчны шинжилгээний лаборатори:*

Агаарын чанарын хүхэрлэг хий, азотын давхар ислийн сорьц авч шинжилгээг хийн агаарын чанарыг тодорхойлж байна. Агаарын чанарын ажиглалтыг 07 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар нийт 23 удаа хийсэн ба хүхэрлэг хийн дундаж агууламж  $0.001 \text{ мг/м}^3$  азотын давхар ислийн дундаж агууламж  $0.006 \text{ мг/м}^3$  үзүүлэлттэй байна. Энэ нь 2019 оны 07 дугаар сартай харьцуулахад хүхэрлэг хийн дундаж агууламж  $0.001 \text{ мг/м}^3$ -ээр, азотын давхар ислийн дундаж агууламж  $0.003 \text{ мг/м}^3$ -ээр тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

*Гадаргын усны чанар:*

Усны чанарын хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу 07 дугаар сард Туул-Лүн, Туул-Заамар, Хэрлэн-Мөнгөнморьт голын хяналт шинжилгээний цэгээс усны сорьц авч химийн найрлага, чанарын үзүүлэлтүүдийг тодорхойллоо. Шинжилгээний дүнгээс үзэхэд голын усны эрдэсжилтүүд 31-180 мг/мл байсан ба голын ус органик бодисын болон эрдэс азотын бохирдолгүй цэвэр байсан.

*Ус судлалын салбар:*

Төв аймгийн нутаг дэвсгэрт 7-н ус судлалын харуул ажиллаж байгаагаас 2020 оны 07 дугаар сарын 21-ний байдлаар усны түвшин Туул гол Туул-Алтанбулаг харуул 600 см, Туул-Лүн харуул 226 см, Туул-Заамар харуул 218 см, Хэрлэн гол Хэрлэн-Хонгон харуул 149 см, Хэрлэн-Мөнгөнморьт харуул 165 см, Сөгнөгөр гол Сөгнөгөр-Сөгнөгөр харуул 216 см, Шивэрт гол Шивэрт-Борнуур харуул 137 см тус тус байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад усны харуулуудын усны түвшин 4-42 см-ээр их байна.

**Тав. Нийгмийн бодлогын хэлтсийн хүрээнд:**

1. Аймгийн ИТХурлын XVII хуралдаанд “Сумдын хамгаалалтад байх Түүх соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт баталж, орон нутгийн хамгаалалтад авах тухай” асуудлыг хэлэлцүүлэн батлууллаа.

2. Нийгмийн салбарын хүрээнд төсвийн Ерөнхийлөн захирагч болон Төв аймгийн Засаг даргын хооронд 2020 онд засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний хэрэгжилтийг холбогдох яамдын сайд нарт хугацаанд гаргаж хүргүүлээ.

3. Өрхийн эрүүл мэндийн төвийн даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтийг дүгнэх ажлын хэсгийг байгуулж дүнг ЗДЗ-ийн хурлаар хэлэлцүүлэв.

4. Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургууль, Эрдэнэ, Баянцагаан сумдын ЕБС-иудад Үдийн цайг Үдийн хоол болгох хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор БНХАУ-ын төсөл хөтөлбөрөөр 140,000 долларын санхүүжилтээр их засвар хийх, тоног төхөөрөмж нийлүүлэгдэх ажлын бэлтгэлийг хангах зорилгоор судалгааг гаргаж төсөв тооцоог боловсруулан ажиллаж байна.

5. “Хүртээмжтэй чанартай төрийн үйлчилгээний жил” урианы жилийн хүрээнд аймгийн ХХҮГ, ЭМГ, АНЭ зэрэг байгууллагууд ISO9001;2015 чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлж, баталгаажилт, батламжаа гардан авлаа.

**Боловсрол, соёл, урлагийн газар:**

1. Төв аймгийн хэмжээнд 12 дугаар анги төгсөгч болон өмнөх жилийн төгсөгч нарын ЭЕШ-ыг 2020 оны 07 дугаар сарын 02-05-ны өдрүүдэд 10 судлагдахуунаар зохион байгууллаа. Шалгалтын ирц 90% байна.

*Судлагдахуун бүрээр:*

| №           | Хичээлийн нэрс        | Хугацаа    | Шалгуулагчийн тоо | Шалгуулагчийн тоо | ирээгүй    | ирц          |
|-------------|-----------------------|------------|-------------------|-------------------|------------|--------------|
| 1           | Монгол улсын түүх     | 2020.07.02 | 36                | 16                | 20         | 44.4%        |
| 2           | Англи хэл             | 2020.07.02 | 483               | 431               | 52         | 89.2%        |
| 3           | Хими                  | 2020.07.03 | 142               | 128               | 14         | 90.1%        |
| 4           | Газар зүй             | 2020.07.03 | 39                | 30                | 9          | 76.9%        |
| 5           | Нийгмийн тухай мэдлэг | 2020.07.03 | 560               | 522               | 38         | 93.2%        |
| 6           | Биологи               | 2020.07.04 | 149               | 136               | 13         | 91.3%        |
| 7           | Математик             | 2020.07.04 | 610               | 570               | 40         | 93.4%        |
| 8           | Физик                 | 2020.07.05 | 285               | 252               | 33         | 88.4%        |
| 9           | Орос хэл              | 2020.07.05 | 18                | 13                | 5          | 72.2%        |
| 10          | Монгол хэл            | 2020.07.05 | 369               | 324               | 45         | 87.8%        |
| <b>Бүгд</b> |                       |            | <b>2691</b>       | <b>2422</b>       | <b>269</b> | <b>90.0%</b> |

*Ариутгал халдваргүйжилтын талаар авсан арга хэмжээ:*

Төв аймгийн МХЕГ болон ЭМГ, аймгийн Онцгой комиссоос 4000 ширхэг нөөц маск, иж бүрдэл хувцас, халуун хэмжигч, бэлтгэсэн байсан ба БҮТ-ээс олгогдсон ариутгалын материалуудыг (гар ариутгагч, салфетка, нөөц маск г.м) анги тус бүрт тусгай буланд байрлуулж, эмчид бээлий, тусгаарлах хувцас-2, үйлчлэгч нарт цэвэрлэгээний материалыг хүлээлгэн өгч тухай бүр ариутгаж, тусгаарлах 2 байранд хэрэгцээтэй бүх зүйлсийг бэлтгэн ажиллалаа.

Цагийн хуваарийн дагуу тухайн хичээлийн хянагч багш нарт гэрээний хуудсыг шалгалт эхлэхээс 1 цаг 30 минутын өмнө тараан, шалгуулагчдыг халууныг үзэн, гарыг ариутгаж бээлий, маск өгч, металл илрүүлэгчээр шалгуулан шалгуулагчдыг нэвтрүүлсний дараа баримт бичгүүдийг шалган шалгалтыг цагт нь эхлүүлж ямар ч гомдол чирэгдэлгүй маш сайн зохион байгууллаа.

*Цахим мэдээллийн хүрээнд:*

БСУГ-аас “live” хийх заавар, дата, утас, цэнэглэгч, power bank зэргийг бэлтгэж, Боловсролын үнэлгээний төвөөс зөвшөөрөл авч аймгийн “Төв” телевизээр засалтыг хязгаарлалтын нөхцөлтэйгээр (хөтлөгчгүй, зураглаачийн камер зөвхөн дэлгэц дээр гарах оноо танилцуулахаар байрлах) шууд дамжуулж сум болон хөдөө орон нутагт эцэг эхчүүдэд нээлттэй хүргэлээ.

2. ЭЕШ-ын дүн гарсны дараа нийт 797 төгсөгчийн батламжийг БҮТ-өөс авчран 2020 оны 07 дугаар сарын 08-наас 07 дугаар сарын 16-ныг дуустал хугацаанд ЕБС-иудын удирдлагын дуудан БСУГ-аас тарааж олгох ажлыг зохион байгууллаа.

3. Нийт төгсөгчдийн хуваарь олголтыг бүх их дээд сургуулиуд цахимаар зохион байгуулж байгаа талаар мэдээллийг БСУГ-ын “Вэб” сайтаар дамжуулан төгсөгчид, эцэг эхчүүдэд мэдээллийг хүргэж ажиллалаа.

4. 2020 оны 07 дугаар сарын 16-наас 07 дугаар сарын 25-ныг хүртэлх хугацаанд аймгийн хэмжээний нийт боловсрол, соёл урлагийн байгууллагуудын 2021 оны төсвийн төсөөллийг хүлээн авч дуусган нэтгэлээ хийж 08 дугаар сарын 01-ний дотор Сангийн болон БСШУ-ны яаманд хүргүүлэхээр ажиллаж байна.

**Монгол туургатан театр:**

1. Тулгар төр байгуулагдсаны 2229, Их Монгол улс байгуулагдсаны 814, Ардын хувьсгалын 99, Төв аймаг байгуулагдсаны 97 жилийн ойн их баяр наадмын “Хүндэтгэл”-ийн тоглолт, “Нээлтийн арга хэмжээ”-г тус бүр зохион байгууллаа.

2. Монгол улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын уран зохиолч Б.Лхагвасүрэнгийн “Улаан тэргэл сар” драммын жүжгийг шинээр найруулан тавихаар бэлтгэл сургуулилт хийгдэж байна.



3. Төв аймгийн Алтанбулаг суманд 2020 оны 07-р сарын 25-нд аялал жуулчлалын эвент “Хонины найр” арга хэмжээнд уран бүтээлчдийн төлөөлөл оролцлоо.

#### **Нийтийн номын сан:**

1. Аймгаас БНСУлсын Пенгтаек хотын харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд 1.2 тэрбум төгрөгийн “Нийтийн номын сан”-гийн засвар шинэчлэлийн ажил эхэлж 50%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

2. Ажлын байр их засварт орж нүүлгэн шилжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэн аймгийн БСУГазарт байрлан дотоод үйл ажиллагаагаа явуулж байна.

#### **Музей:**

1. Улсын онцгой комиссоос шийдвэрлэсний дагуу 2020 оны 7 дугаар сарын 11-ны өдрөөс эхлэн үйл ажиллагааг эхлүүлэн Төв болон Манзушир дахь салбар музейгээр нийт 206 үзэгч үйлчлүүлж 885.000 төгрөгийн орлого орсон байна.

2. Нийт 2.0 сая төгрөгөөр гадаад харилцааны танхимын Буриад, Курган, Жилинь, Тоттори мужийн булангууд болон Угсаатны зүйн танхимыг шинэчлэн засварын ажлыг хийж Угсаатны зүйн танхимд 90 дэсийн 110 үзмэр үзүүллэгийг шинээр дэглэлээ.

3. Түр үзэсгэлэнгийн танхимд Төв аймгийн зураач, урчуудын бүтээлээр түр үзэсгэлэнг зохион байгууллаа.

#### **Биеийн тамир, спортын газар:**

1. "Дугуйтай Төв аймагчууд" эрчтэй хүчтэй эрүүл амьдаръя нийтийн биеийн тамир, их спорт, идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих аяны нээлтийн үйл ажиллагааг 2020 оны 07-р сарын 04-ны өдөр дугуйн аялалыг зохион байгуулж 42 хүн хамрагдлаа. Энэ үеэр дугуйн тохиргоо, тосолгоо үйлчилгээг явуулж “С” витамин халуун чацаргана болон иргэдэд спортын бэлэг гардууллаа.

2. Чөлөөт бөх болон Үндэсний бөхийн шигшээ багийн тамирчдын зуны нэгдсэн бэлтгэл цугларалтыг 2020 оны 07-р сарын 01-ны өдрөөс 14 хоног Төв аймгийн Эрдэнэ суманд зохион байгуулж 41 тамирчин хамрагдлаа.

3. Цана, тэшүүр, дугуйн тамирчдын зуны нэгдсэн бэлтгэл цугларалтыг зохион байгуулж 29 тамирчин хамрагдлаа.

4. Их Монгол улс байгуулагдсаны 814, Ардын хувьсгалын 99, Төв аймаг байгуулагдсаны 97 жилийн ойн их баяр наадмын үндэсний бөх, сур, шагайн харвааг зохион байгуулж эмэгтэй 8, эрэгтэй 246 нийт 254 тамирчин хамрагдлаа.

#### **Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар:**

1. Нийгмийн халамжийн чиглэлээр:

##### **Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт үйлчилгээ**

2020 оны 7 дугаар сарын байдлаар 1831 иргэнд 2849,8 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 1197 иргэнд 702.5 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэмж, 1280 иргэнд 436.2 сая төгрөгийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, 849 ахмад настанд 182.0 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж, 5210 ахмад настанд 820.7 сая төгрөгийн насны хишиг, 263 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 50.1 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж, хүнс тэжээлийн тусламж шаардлагатай 6826 иргэнд 561.9 сая төгрөг, жирэмсэн 1899 эхэд 175.1 сая төгрөгийн тэтгэмж, алдар цолтой 60 ахмад настанд 64.3 сая төгрөг, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарсан 6150 эхэд 1477.9 сая төгрөг, өрх толгойлсон 292 эхэд 240.3 сая төгрөг, 2 ихэр хүүхэд төрүүлсэн 13 эхэд 26.0 сая төгрөг, алдарт эхийн 1,2-р зэргийн одонтой 8998 эхэд 1177.0 сая төгрөгийн тэтгэмж тусламжийг тус тус олголоо.

##### **Өрхийн мэдээллийн нэгдсэн сан, хүүхдийн мөнгөний талаар**

Шинэ төрсөн 195 хүүхдийн мэдээллийг өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн. ӨМНСанд бүртгэлтэй 18568 өрхийн 32993 хүүхдэд сар бүр хүүхдийн мөнгөн тэтгэмжид харагдаж байна. ХЭБ-ийн үйлчилгээнд 1212 өрхийн 3338 том хүн, 3488 хүүхдэд сард 256.2 сая төгрөгийн хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлсэн.

2. Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

##### **Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сан:**

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд 41 иргэнийг ажил хайгчаар бүртгэж, 37 ажил олгогч байгууллага, иргэн, 35 сул чөлөөтэй ажлын байр, 13-н ажилд зуучлагдсан иргэн, 66 шинэ /байнгын болон түр/ ажлын байрны мэдээллийн санд оруулж ажиллалаа.

Ажилгүйдлийн тэтгэмжинд хамрагдах 21-н иргэнд бүртгэлд хамрагдсан тодорхойлолтыг гаргаж холбогдох байгууллагад хүргүүллээ.

***Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд:***

*Залуучуудын хөдөлмөр эрхлэлт гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд:*

GSAS зэрэг сургалтын төвөөр дамжуулан Баянцагаан, Борнуур, Жаргалант, Зуунмод, Батсүмбэр сумдын 27 иргэнд 5 хоногийн аж ахуй эрхлэлтийн сургалтыг зохион байгуулж, 810,0 мянган төгрөгийн санхүүжилтийг олголоо.

Тус хөтөлбөрийн хүрээнд гарааны бизнесийг сургалтын эхний шатны сургалтыг GSAS сургалтын төвтэй хамтран зохион байгуулж нийт 11 баг хамрагдсанаас эхний шатны шалгаруулалтанд 7 багийн 16 оролцогч шалгарсан байна.

Эдгээр 7 бүлэг цаашид 35 хоногийн хурдасгуур хөтөлбөрт хамрагдан 2-р шатны шалгаруулалт хийгдсний дараа гарааны санхүүжилт олгогдоно.

***Нийгмийн даатгалын хэлтэс:***

1. Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлыг 3 удаа 21 цаг хуралдаж, нийт 184 иргэний асуудлыг хэлэлцсэнээс шинээр 17 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг тогтоож, 159 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгаж, 8 иргэнийг цуцалсан байна.

2. Төсвийн тухай хуулиар 2021 оны төсвийг хуулийн хугацаанд нь НДЕГазар өргөн барив.Нийгмийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны хагас жилийн орлого, зарлагын нэгдсэн тайлаг бэлтгэн НДЕГ-ын санхүү бүртгэлийн газарт хүргүүлэн ажиллав.

3. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан зорилт арга хэмжээ, урианы жилийн хэрэгжилтэд тусгагдсан арга хэмжээний удаашралтай заалтад төлөвлөгөө гарган үр дүнг ахиулахаар ажиллаж байна.

4. Төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн системд байгууллагын 53 албан хаагчийн мэдээллийг бүрэн оруулан ажилласан.

5. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу 14861 тэтгэвэр авагчдад 5,6 тэрбум төгрөгийн тэтгэврийг арилжааны 2 банкаар дамжуулан цаг хугацаанд олгон ажилласан.

6. Монгол Улсын Засгийн газрын 140-р тогтоолоор батлагдсан Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөгдөх, Ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай журмын хэрэгжилтийг ханган ажиллалаа. 2020 оны 7 дугаар сарын 25-ны байдлаар 536 ААН-ийн 3005 даатгуулагчийг Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл, үйлдвэрлэлийн ослын даатгалын зэрэг 4 сангийн 1,1 тэрбум төгрөгийн шимтгэлээс бүрэн чөлөөлсөн.

Мөн ЗГ-ын шийдвэрийн дагуу 4292 Сайн дурын даатгуулагчийн чөлөөлөлтөд 728,1 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд Татварын ерөнхий газраас ирүүлсэн үйл ажиллагаа нь доголдсон, орлого нь буурсан ААН-ийн жагсаалтад хамрагдсан 44 Ажил олгогчид 155,6 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус олгоод байна.

7. Аймгийн хэмжээнд 46 архивын лавлагаа, 15 тодорхойлолт нийт 61 лавлагаа, тодорхойлолт гарган иргэд даатгуулагчдад өгч ажилласан.

8. Тайлант сард ХЧТАлдсаны тэтгэмжийг 78 даатгуулагчид 9,0 сая төгрөг, жирэмсэн амаржсаны тэтгэмжийг 66 эхэд 86,8 сая төгрөг, оршуулгын тэтгэмж 17 иргэнд 17 сая төгрөг, 31 ажилгүй болсон даатгуулагчид 65,5 сая төгрөгийн тэтгэмжийг тэтгэмжийн сангаас тус тус олгон ажилласан байна.

***Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар:***

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь Их Монгол улс байгуулагдсаны 814 жил, Ардын хувьсгалын 99 жил, аймаг байгуулагдсаны 97 жилийн ой, сумын баяр наадмын үед хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хурдан морины уралдаанч хүүхдийн аюулгүй байдалд хяналт тавьж, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2020 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 01/417 дугаартай албан тоот, “Үндэсний их баяр наадмын үед хүүхдийн аюулгүй байдлыг ханган ажиллах үйл ажиллагааны удирдамж”-ийн дагуу

хурдан морины уралдаанч хүүхдийн бүртгэлийг хүүхдийн бөөгнөрөл үүсгэхгүйгээр 06 дугаар сарын 29-ны өдрөөс 07 дугаар сарын 08-ны өдрүүдэд ГБХЗХГ дээр төвлөрүүлэн зохион байгуулан ажилласан.

Хурдан морины уралдааны үед Үндэсний морин уралдааны уралдаанч хүүхдийн хамгаалалтын хувцас, морин хэрэгсэлд тавигдах шаардлага MNS 6264:2018 стандартын хэрэгжилтийг хангаж хамгаалалтын иж бүрэн хувцас хэрэглэлгүй, бүртгэл хийлгээгүй хүүхдийг уралдаанд оролцуулаагүй.

Мөн аймгийн баяр наадмын үед онлайн горимонд картаар хүүхдийн бүртгэлийг баталгаажуулан гаргаж аюулгүй байдалд хяналт тавин ажиллалаа.

Аймгийн баяр наадамд 429 хүүхэд гараанаас гарч 19 хүүхэд, сумдын баяр наадамд 4882 хүүхэд гараанаас гарч 53 хүүхэд мориноос унасан байна. Унасан хүүхдүүдийн хувьд ямар нэг гэмтэл аваагүй, сумын эмнэлгээс анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлээд эцэг эх, асран хамгаалагч нарт нь хүлээлгэн өгсөн байна. Бэртгэл гэмтэл авч дараагийн шатлалын эмнэлэгт хандсан хүүхэд байхгүй болно.

Төв аймгийн ГБХЗХГ-ын даргын 2020 оны 07 сарын 01-ний өдрийн А/48 дугаартай тушаалаар баяр наадмын үед хүүхдийн аюулгүй байдлыг хангах, бүртгэл хийж хяналт тавих ажлын хэсгийг байгуулан, байгууллагын ажилтан албан хаагчид бүрэн бүрэлдэхүүнээрээ ажилласан. Хүүхэд хамгааллын зардлаас 3.187.930 төгрөгийг зарцууллаа.

#### *Хоёр. Хүүхэд хамгааллын чиглэлээр хийгдсэн ажлууд:*

2.1. “Эрсдэлгүй ирээдүй” аяны хүрээнд: Хүүхэд ахуйн осолд өртөж гэмтэх улмаар амь насаа алдах эрсдэлүүд гардагтай холбогдуулан хүүхдийг болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах зорилготой “Эрсдэлгүй ирээдүй” аяны хүрээнд аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, аймгийн Цагдаагийн газар, Зуунмод сумын ГХУССЗөвлөлтэй хамтран 2020 оны 07 дугаар сарын 01-ны өдөр Зуунмод сумын Номт 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах 19 хүүхдийн тоглоомын талбайгаар явж, хяналт шалгалт хийж ажиллалаа.

2.2. Монгол улсын Шадар сайд, улсын Онцгой комиссын даргын 2020 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн “Коронавируст халдварт цар тахлын үед хүүхдийн зуслан ажиллуулах түр журам”, “Хүүхдийн эрхийн тухай хууль”, “Хүүхэд хамгааллын тухай хууль”, “Эрүүл ахуйн тухай хууль”, “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль”, “Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа, ерөнхий шаардлага MNS5633:2019 стандарт” зэрэг хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд 2020 оны 07 дугаар сарын 20-21-ны өдрүүдэд Төв аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, аймгийн Онцгой байдлын газар хамтран Батсүмбэр сумын нутаг дэвсгэрт байрлах “Цоглог”, “Цагаан нуга”, “Мөрөөдөл” хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг зохион байгуулан ажиллалаа.

2.3. Ковид-19 цар тахлын улмаас Бүгд найрамдах Энэтхэг улсад шавилан суудаг ламхай нар эх орондоо ирсэн. Үүнээс: Баянжаргалан /1/, Дэлгэрхаан /4/, Өндөрширээт /1/, Сэргэлэн /2/, Эрдэнэ /1/ сумын нийт 9 өрхөд нөхцөл байдлын үнэлгээг сумдын “Хамтарсан баг”-ийн Нийгмийн бодлогын мэргэжилтэнтэй хамтран гэр бүлд нь очиж хийсэн. Нөхцөл байдлын үнэлгээний дагуу 6 айлд хүнсний тусламжийг үзүүлж, Хүүхэд хамгааллын зардлаас 390720 төгрөг зарцуулаад байна. Одоогийн байдлаар ламхай нараас хөгжлийн чиглэлийн арга хэмжээнд хамрагдах хүсэлт ирүүлээгүй байна.

2.4. 2020 оны 06 дугаар сарын 21-нд Зуунмод, Алтанбулаг суманд, 07 дугаар сарын 09-12-ний өдрүүдэд Бүрэн, Эрдэнэ суманд болсон байгалийн гамшиг-үерт өртсөн 13 айл өрхийн 34 хүүхэд, түүний гэр бүлд хүнс, зөөлөн эдлэл, гутал хувцасны тусламжийг үзүүлэн ажиллаж байна. Хүүхэд хамгааллын зардлаас 6.122.000 төгрөгийг зарцуулан ажиллаж байна.

#### **Эрүүл мэндийн салбарын хүрээнд:**

1. Аймгийн хэмжээнд 2020 оны 06 сарын байдлаар 557 эх төрж өнгөрсөн мөн үеийнхээс 4 тохиолдлоор өссөн ба 559 нярай бүртгэгдсэн байна. Нийт 166927 үзлэг хийсэн бөгөөд үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 67669, амбулаторийн үзлэг 69060, идэвхтэй хяналтын 14078 үзлэг хийж гүйцэтгэсэн байна. Түргэн тусламжийн дуудлагаар 9644 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн ба үүнээс алсын дуудлага 2451 буюу 25.41%, осол гэмтлийн дуудлага 281 буюу 2.92%-ийг эзэлж байна. Стационарт 7369 хүн эмчлэгдэн нийт 54201 ор хоног ашигласан. Дундаж ор хоног 7,4 байна.

2. Халдварт өвчний сэжигтэй 9 тохиолдол бүртгэгдсэн. Үүнд: хачигт халдвар 1, салхин цэцэг 1, дезинтери 5, гэдэсний бусад бактерит өвчлөл 2 бүртгэгдсэн байна. Тархвар зүйн судалгааг хийж голомтын ариутгал, халдваргүйтгэл хийлээ. Хачигт халдварын 1 сорьцийн шинжилгээг ЗӨСҮТ-д хүргүүлсэн.

3. Ариутгал, халдваргүйжүүлэлтийг 11 объектын 812 мкв талбайд хийж гүйцэтгэсэн. Үүнд: Баянхангай амралтын газар эцсийн халдваргүйжүүлэлт, аймгийн наадмаар 7 гэр, 3 гуанзанд урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт хийлээ.

4. Төв аймгийн нутаг дэвсгэр дээр байрлах тусгаарлан ажиглах байранд нийт 130 иргэн 21 хоног тусгаарлагдсан. Гэрийн тусгаарлалтад нийт 15 иргэн 7 сумын Эрүүл мэндийн төвийн хяналтад ажиглалтад байна.

5. Улсын Онцгой комиссоос “Хариу арга хэмжээний бэлэн байдлыг үнэлэх, тохиолдлын удирдлагын тогтолцоонд дэмжлэгт хяналт хийх удирдамжийн дагуу МХЕГ, ОБЕГ, ХӨСҮТөв-ийн салбар хоорондын дэд ажлын хэсэг 2 өдөр ажилласан. Тохиолдлын удирдлагын тогтолцоогоор ажиллах бүтэц үйл ажиллагааны талаар сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр ханган, цаашид хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангуулах зорилгоор үүрэг чиглэл өгсөн. Хариу арга хэмжээний бэлэн байдлыг үнэлэх, тохиолдлын удирдлагын тогтолцоонд дэмжлэгт хяналт хийсэн ажлын хурлын тэмдэглэл болон төлөвлөгөөг Аймгийн Онцгой комисст хүргүүлсэн.

6. Эх барих эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээтэй холбоотой Зуунмод сумын 3-р багийн иргэнээс ирсэн 2019 оны 5 дугаар сард гарсан тохиолдлын талаарх өргөдлийг судлан, холбогдох эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд хариуцлага тооцох, тухайн хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээнд онцгой анхааран, эцэг, эх, асран хамгаалагчдад нь зөвлөгөө өгөх зэрэг бусад шаардлагатай арга хэмжээ авч ажиллах талаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн удирдлагад хугацаатай үүрэг чиглэл өгч, хариуг авч албан тоотоор НБХ-т хүргүүлсэн.

7. Эх баригч нарын ажлын байрны дадлага сургалтын удирдамж, хөтөлбөрийг боловсруулан батлуулж, аймгийн Нэгдсэн эмнэлэгт хүргүүлсэн. Өндөрширээт сумын эх баригч АНЭ-ийн төрөх тасагт 6 дугаар сарын 29-ний өдрөөс 12 хоногийн дадлага сургалт хийж, амжилттай хамгааллаа.

8. ЭМГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу Бүрэн суманд тохиолдсон амьгүй төрөлтийн тохиолдлыг магадлан хэлэлцэх эмнэл зүй-эмгэг судлалын хурал зохион байгуулан, материалыг ЭХЭМҮТ-ийн тандалт судалгааны албанд хүргүүллээ.

9. “Тарваган тахлаас урьдчилан сэргийлэх” ЭМС-ын 2020 оны 06 сарын 04-ний А/318 тоот тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор “Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед үзүүлэх тусламж үйлчилгээний шинэчлэгдсэн журмын хэрэгжилтийг хангах нь” сэдэвт цахим сургалт 26 сум, ӨЭМТ, АНЭ-ийн эмч, эмнэлгийн ажилчдад зохион байгууллаа.

10. “Эрүүл ахуйн аян”-ны хүрээнд Зуунмод сумын 29 өрхөөс нүхэн жорлонгийн эрүүл ахуйн судалгаа авч НЭМҮТ-д хүргүүллээ.

11. НЭМХ-ээс “Урьдчилан сэргийлэх аян”-ы хүрээнд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар сум, өрх, НЭ-ийн эмч, НЭМА- нартай цахим хурлыг зохион байгууллаа.

1 2. ЭМГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу “Урьдчилан сэргийлэх үзлэгийг иргэн бүрт” аян, “Эмэгтэйчүүд, хүүхдийн ЭМД” аймгийн хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, эрүүл зохистой хооллолтыг дэмжих чиглэлээр Баян, Баян-Өнжүүл, Баянцагаан сумдад дэмжлэгт хяналт хийн ажиллалаа.

13. 14 эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл сунгасан байна.

14. Эрүүл мэндийн тухай хуулийн 29.2, 29.5 дах заалтын дагуу 2021 онд тэтгэмжид хамрагдах 188, тэтгэвэрт гарах 40 эмч, эмнэлгийн мэргэжилтний материалыг хянаж, төсвийн төсөлд хүлээн авсан.

### **Зургаа. Санхүү, төрийн сангийн хэлтсийн хүрээнд:**

#### *Төсвийн орлогын талаар:*

Орлогын төлөвлөгөө 6 дугаар сарын байдлаар орон нутаг 2499,2 сая төгрөг төвлөрүүлэхээс 2599,9 сая төгрөг төвлөрүүлж 104 хувьтай, 4 хувиар буюу 100,7 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Аймгийн төвлөрсөн төсвийн орлого 7660,2 сая төгрөг төвлөрүүлэхээс 8734,3 сая төгрөг төвлөрүүлж 114 хувьтай, 1074,1 сая төгрөгөөр буюу 14 хувиар биелүүлсэн байна. 3 шатны орлогын төлөвлөгөөний биелэлт нийт 1591,5 сая төгрөгөөр давуулан биелүүлж, 113,2 %-тай байна. 3-н шатны орлогын төлөвлөгөөгөө биелүүлсэн Аргалант, Батсүмбэр, Баяндэлгэр, Баян-Өнжүүл, Баянхангай,

Баянцагаан, Баянцогт, Бүрэн, Дэлгэрхаан, Лүн, Өндөрширээт, Сүмбэр, Сэргэлэн, Угтаал, Эрдэнэсант, Цээл, Борнуур, Баянжаргалан, Баянчандмань, зэрэг 18 сум, 2 шатны төлөвлөгөө тасалсан Баян сум, 1 шатны төлөвлөгөө тасалсан Алтанбулаг, Архуст, Борнуур, Жаргалант, Зуунмод зэрэг 8 сум байна.

*Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:*

Сумдад эхний 06 сарын байдлаар нийт 45598,6 сая төгрөгийн зарлага санхүүжилтийг 27 сум, тэдгээрийн харьяа төсвийн байгууллагуудад олгосон.

Салбараа авч үзвэл:

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцаас 24255,0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Үүнд:

-Ерөнхий боловсролын сургуулиудад 16594,6 сая төгрөг

-Хүүхдийн цэцэрлэгт 7660,4 сая төгрөг тус тус олгоод байна.

Эрүүл мэндийн сайдын багцаас 4551,6 сая төгрөгийг олгосон. Үүнд:

-Сумдын эрүүл мэндийн төвд 4331,1 сая төгрөг

-Өрхийн эмнэлэгт 220,5 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгов.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт 371.7 сая төгрөг, Хүүхэд гэр бүл, залуучуудын хөгжлийн газарт 305.8 сая төгрөгийн зарлага санхүүжилт тус тус олгоод байна.

Нийтийн ерөнхий үйлчилгээний салбарт 16114,5 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Үүнээс:

-Сумдын ИТХ, ЗДТГазар, Соёлын төвүүдийн санхүүжилтэд 10109.5 мянган төгрөг

-Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудад 6005,0 мянган төгрөгийн санхүүжилт тус тус олгоод байна.

*Өр, авлагын талаар:*

2020 оны 6-р сарын байдлаар сумд, болон төсөвт байгууллагууд нийт ,222105,9 мянган төгрөгийн авлага, 166265.8 мянган төгрөгийн өглөгтэй байна.

Нийт өглөгийн 28086,0 мянган төгрөг буюу 16.9 хувь нь түлш, халаалтын зардлын өглөг, 11646,0 мянган төгрөг буюу 7.0 хувь нь цалингийн өглөг, 3179.4 мянган төгрөг буюу 1.9 хувь нь НДШимтгэлийн өр, 7063.2 мянган төгрөг буюу 4.2 хувь нь гэрэл цахилгааны зардлын өглөг, 49621.8 мянган төгрөг буюу 29.8 хувь эмийн зардлын өглөг, үлдсэн 66669,4 мянган төгрөг буюу 40,2 хувийг бусад өр эзэлж байна.

Долоо. Хяналт-шинжилгээ, дотоод аудитын хэлтсийн хүрээнд:

**Долоо. ХШҮДАХ-ийн хүрээнд:**

*ХШҮ-ний чиглэлээр:*

1. Аймгийн эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг аймгийн ИТХТэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж, 2020 оны хагас жилийн байдлаар 96 зорилтын 261 арга хэмжээ 75.57 хувьтай 3.78 оноотой дүгнэгдсэн. Үүнээс 100%-71, 70%-139, 40%-27, үнэлэх боломжгүй-24 арга хэмжээ байна.

2. Аймгийн ИТХ, ИТХТ-ийн тогтоол, тэмдэглэлийн хэрэгжилтэд Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” журам”-ын үнэлгээний аргачлалаар ХШҮ хийж аймгийн ИТХТэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж. 2020 оны хагас жилийн байдлаар 68 шийдвэрийн 193 заалтын хэрэгжилт 79.58%-тай байна.

3. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 22 агентлаг, 5 харьяа байгууллагын 2020 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн явцын дундаж 88.6%, өмнөх оны мөн үеэс 7,74 хувиар өссөн байна.

А үнэлгээтэй 17, В үнэлгээтэй – 10 байгууллага дүгнэгдлээ. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад “А” үнэлгээтэй байгууллага 16-аар өсч, “В” үнэлгээтэй байгууллага 8 буурч, үйл ажиллагааны үнэлгээ 2.11-22.37 пунктээр 26 байгууллага өссөн бол 1 байгууллага 0.47 хувиар буурсан байна. Агентлагаас Улсын бүртгэлийн хэлтэс, Харьяа байгууллагаас Нийтийн номын сан тус тус тэргүүлсэн байна.

*Бусад:*

Аймгийн баяр наадмыг зохион байгуулах хороо, үндэсний бөхийн салбар хороонд тус тус 1 албан хаагч ажиллаж баяр наадмын зохион байгуулалж ажиллав.

**Найм. Цэргийн штабын хүрээнд:**

Тулгар төрийн 2229 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 814 жил , Ардын хувьсгалын 99 жилийн ой, Аймаг байгуулагдсаны 97 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулах ажлын хүрээнд хурдан морины салбар хороонд орж, гарааны төхөөрөмж дээр ажилласан.

Аймгийн баяр наадмын ажлын хүрээнд Төрийн нийгмийн нэрт зүтгэлтэн, Монгол Улсын анхын ерөнхий сайд Д. Бодоогийн хөшөөнд цэцэг өргөх ёслолын арга хэмээг зохион байгуулах ажлын албан тоотыг гаргаж, ЗХ-ний 016 дугаар нэгтгэл ангитай хамтран ажилласан.